

**ЗАМЫН ЦАГДААГИЙН АЛБАНЫ НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ХЯНАЛТЫН
ГАЗРЫН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ ДЭХ ЗАМЫН ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН 2017 ОНД
ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2017.12.05

Улаанбаатар хот

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын талаар:

а. Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Хууль зүй дотоод хэргийн яам болон дээд шатны байгууллагаас гаргасан хөтөлбөр, төлөвлөгөө, үүрэг, ажлын чиглэл болон холбогдох эрх зүйн баримт бичигт тусгагдсан ажил, ажил арга хэмжээний хэрэгжилтийг хангах чиглэлээр:

Тус хэлтэс нь Хууль зүй дотоод хэргийн сайдын А/87, А/133, Монгол Улсын Ерөнхий Прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан А/03, А/04, Монгол Улсын Ерөнхий Прокурорын газрын Тамгын газрын даргын 2/2821 Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны даргын 3/3086, Цагдаагийн ерөнхий газрын даргын А/96, А/99, А/121, А/122, 01/441, 01 тоот албан даалгавар, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Хууль сахиулах их сургуулийн захирлын хамтарсан А/132, А/135, Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд даргын 2/297, 3/236 Цагдаагийн ерөнхий газрын дэд даргын 3/216, Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын даргын А/103, 5/135,191, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн даргын бд/2252, 2852, бд/3099, 3132, 5д/4705, 4873, Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл нэгтгэн боловсруулах газрын даргын 8/1414, Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөц сургалтын хэлтсийн даргын 5б/3127, 5б/3180, Нийслэлийн Засаг даргын 2017 оны 07 дугаар сарын 03-ны А/500, Эрүүл мэнд нийгмийн даатгалын газрын даргын А/78, Замын цагдаагийн албаны даргын 8/09, 8/57, 8/438, 8/450, 8/884, Замын цагдаагийн албаны дэд даргын 13-1/1142, 1506, 1731,1738, Захиргааны удирдлагын хэлтсийн даргын 8/04, 8-1/15, 8-1/27, 8-1/35, Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын газрын даргын 8-2/33, 8-2/229 зэрэг албан бичгээр ирүүлсэн нийт 313 тушаал, шийдвэр, үүрэг, ажлын чиглэл, зөвлөмжийг алба хаагч нарт танилцуулан хэрэгжүүлэх чиглэлээр удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж байна.

б.Хүний нөөцийн талаар:

Тус хэлтсээс Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн тушаалаар зохицуулагч, цагдаагийн ахмад Э.Уртнасан Сонгинохайрхан дүүрэг дэх Замын цагдаагийн хэлтсийн ахлах зохицуулагчаар, зохицуулагч, цагдаагийн ахлах дэслэгч Х.Батсайхан Сүхбаатар аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн ахлах зохицуулагчаар, Сэлэнгэ аймгийн Мандал сум хариуцсан ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч Б.Сүхбаатар зохицуулагчаар, Замын цагдаагийн албаны даргын тушаалаар цагдаагийн дэд ахлагч Б.Нямбуу цагдаа зохицуулагчаар тус тус томилогдсон. Ахлах зохицуулагч, цагдаагийн ахмад Б.Зоригт, зохицуулагч, цагдаагийн ахмад Б.Алтандөш нар Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 09-р сарын 18-ны өдрийн Б/400 тушаалаар ХСИС-ийн “Цагдаа судлал” магистрын сургалтад суралцах болсон тул 2017 оны 09 дүгээр сарын 18-аас 11 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэл ажлаас түр чөлөөлөгдсөн. Ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч Ц.Чинзориг Хан-Уул дүүрэг дэх Замын цагдаагийн хэлтэст ахлах зохицуулагчаар, Архангай аймгийн Цагдаагийн газрын замын цагдаагийн тасгийн ахлах зохицуулагч цагдаагийн хошууч Д.Жаргал тус хэлтэст ахлах зохицуулагчаар тус тус томилогдон ажиллаж байна. Зохицуулагч, цагдаагийн хошууч Б.Сүхбаатар 2017 оны 10 дугаар сараас цэргийн байнгын тэтгэвэрт гарч, Баянзүрх дүүрэг дэх замын цагдаагийн хэлтсийн зохицуулагч, цагдаагийн хошууч Ц.Ариунболд тус хэлтэст зохицуулагчаар томилогдон ажиллаж байна.

в. Байгууллагын үйл ажиллагаа түүнийг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

Чингэлтэй дүүрэг дэх замын цагдаагийн хэлтэс нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зам тээврийн осол хэргийг бууруулах чиглэлээр холбогдох хууль, тушаал, шийдвэрүүдийг биелүүлэх, цаг үеийн мэдээ мэдээллийг хэлтсийн бие бүрэлдэхүүнд долоо хоногт 2 удаа хэлтсийн хурлаар алба хаагчдад танилцуулж, долоо хоногийн даваа гаригт хийдэг офицеруудын хурлыг “Сахилгын хурал” болгосноор алба хаагчдын ажлын үр дүн, сахилга хариуцлагын талаар авч хэлэлцэж, сайн ажиллаж байгаа алба хаагчдыг урамшуулах, ажлын алдаа дутагдал гаргасан алба хаагчдыг дахин зөрчил дутагдал гаргуулахгүй байх талаар анхааруулж ажлын үр дүнг тооцон удирдан зохион байгуулан ажиллаж байна. 2017 оны байдлаар Сахилгын хурлыг 38 удаа, сахилгын зөвлөгөөнийг 3 удаа тус тус зохион байгуулж хурлаар хэлтсийн бүх алба хаагчдыг оруулж, тэдний хийж гүйцэтгэсэн ажлын үзүүлэлт, амжилт, алдаа онооны талаар хэлэлцэж, цаашид хэрхэн ажиллах талаар болон өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой 176 төрлийн үүрэг ажлын чиглэл, зааварчилгаа өгч биелэлтэд дээр нь хяналт тавин ажилласан байна. Сахилга ёс зүйн хурлыг тогтмол зохион байгуулснаар хэлтсийн хэвийн үйл ажиллагаа, захирах захирагдах ёс, хүний эрхийг хангах, алба хаагчийн сахилга, хариуцлагыг журамлан зохицуулснаар алба хаагчид ажил албандаа хандах хандлага нь сайжирч ажлын бүтээмж цаг ашиглалтын менежмент нь нэмэгдэж зохион байгуулалт сайжрахад нөлөөлөх ажил болж байна.

Ажлын ачааллыг тэнцвэржүүлэх үүднээс ачаалалтай уулзваруудад /пост/ алба хаагчдыг 7 хоногоор тойруулан жигд байдлаар, бүс хариуцсан зохицуулагч нар гудамж замд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдыг албаны автомашинд тодорхой хугацаагаар суулгаж хөлийг нь амраах, цай, хоолонд орох үед нь хариуцсан постыг хяналтад авах зэрэг ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Албаны бэлэн байдлыг шалгах зорилгоор ЗЦА, НЗХХГ болон хэлтсээс зарласан нийт 14 удаагийн түргэн цугларалтад алба хаагчдыг бүрэн хамруулж, нэг бүрийн тусгай хэрэгсэл, агсамж болон дүрэмт хувцасны өнгө үзэмжийг шалгаж зөрчил заагдсан алба хаагчдад хугацаатай үүрэг өгч зөрчлийг бүрэн арилгуулж бэлтгэл ажлыг хангуулсан.

Сүхбаатарын талбайд эмх замбараагүй байдал үүссэн нөхцөл Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бүлэг хэрхэн ажиллах талаар 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан дадлага сургуулилтад 17 цэгт 36 алба хаагч 06:30 цагаас 07:30 цагийн хооронд хамрагдаж ажилласан.

Замын цагдаагийн албаны дарга, цагдаагийн хурандаа Б.Даваазулын 2017 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 13/3267 дугаартай албан бичгийн дагуу Монгол Улсын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Цагдаагийн ерөнхий газраас хэрэгжүүлэх арга хэмжээний нэг дэх үе шатны төлөвлөгөө /2017-2019 онд/-г Замын цагдаагийн албаны Захиргаа удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн н.Намжилдорж тус хэлтсийн удирдлагууд 2017 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр гардуулсан. Уг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Цагдаагийн ерөнхий газраас хэрэгжүүлэх арга хэмжээний нэг дэх үе шатны төлөвлөгөөг алба хаагч нарт танилцуулж, цаашид хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах үүрэг чиглэл авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

г. Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хийсэн ажил, арга хэмжээ:

Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш Улсын Ерөнхий Прокурорын баталсан “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны бланк”-ыг зөрчлийн хэрэг бүртгэлтэд ашиглаж хэвшээд байна. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэгт зааснаар зөрчлийн хэрэг бүртгэлт хуулийн

хүрээнд явагдаж байгааг хянуулах үүднээс зөрчлийн мэдээг 3 хоногоор нэгтгэн Чингэлтэй дүүргийн хяналтын Прокурорт хүргүүлж хэвшсэн.

2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой зөрчлийн хугацаа алдах, нотлох баримт дутуу бүрдүүлэх зэрэг зөрчил гарсаныг дахин гаргуулахгүй байх үүднээс Чингэлтэй дүүргийн Прокурорын газрын Зөрчлийн хэрэг хариуцсан ахлах прокурор н.Энхтуяа, хяналтын прокурор Х.Даваадулам, хяналтын прокурор Г.Алтантүлхүүр нараар “Зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаа”-ны талаар 3 удаагийн 6 цагийн сургалтыг алба хаагчдад оруулсан. Мөн дээрх зөрчлийг дахин гаргуулахгүй байх зорилгоор зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааны бүртгэлийг хэрхэн алдаа дутагдалгүй бүртгэж хэвших талаар 10 удаагийн зааварчилгааг хэлтсийн даргаас хэрэг бүртгэгч, зохицуулагч нарт өгч өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

Чингэлтэй дүүргийн хяналтын прокурор Н.Алтантүлхүүрт алба хаагчдад чиглэсэн сургалт оруулах хүсэлтийг хүргүүлснээр 12 дугаар сард “Нотлох ажиллагааны талаар” 2 цагийн сургалт зохион байгуулахаар болсон.

д. Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажилласан тухай:

Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2016 оны 12 сарын 28-ны өдрийн А/866 тоот иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гудамж талбайн тохижилтыг сайжруулах зорилгоор нийтийн эзэмшлийн зам, талбайн дээр үйл ажиллагаа явуулж буй зөвшөөрөлгүй байрлуулсан түргэн үйлчилгээний цэг, зөөврийн байгууламж, авто зам, явган хүний зам хаасан объект, эзэмшил, ашиглалтад байгаа газраа дур мэдэн нэмж сунгасан хашаа зэргийг чөлөөлөх, илэрсэн зөрчлийг арилгуулах ажлыг 2016 оны 12 сарын 10-ны өдрөөс эхлэн 2017 оны 10 сарын 15-ны өдрийг дуустал зохион байгуулах тухай захирамжийн дагуу ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч Ц.Чинзориг ажлын хэсэгт орж хамтран ажиллаж 5 дугаар сургуулийн зүүн хойд талд зохих зөвшөөрөлгүй худалдаа үйлчилгээ эрхэлж байсан зөвшөөрөлгүй 19 хашаа, 24 ТҮЦ, 2 гражийг дүүргийн цагдаагийн 1 дүгээр хэлтэс болон үйлдвэр үйлчилгээний хэлтэстэй хамтран нүүлгэн шилжүүлсэн.

Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газар, Иргэдийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, прокурор, мэргэжлийн хяналт, газрын алба, онцгой байдлын хэлтсүүдтэй хамтран 01 сарын 13-ны өдөр 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Тэнгис кинотеатрын Б зааланд, 01 сарын 16-ны өдөр 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах сүмийн хурлын зааланд тус тус 1-19 дүгээр хорооны иргэдэд “Замын цагдаагийн хэлтсээс 2016 онд хийсэн ажлын тайлан” -г иргэдэд хүргэсэн.

Замын цагдаагийн хэлтэс нь 2017 оны эхний сард Чингэлтэй дүүргийн 1-19 дүгээр хороодын засаг дарга, иргэдийн нийтийн хурлын дарга нарт 2016 онд хийсэн ажлаа танилцуулж зам тээврийн осол хэргийг бууруулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх чиглэлээр 19 засаг даргатай 2017 онд хамтарч ажиллах гэрээ байгуулан төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.

Хэлтсийн дарга цагдаагийн дэд хурандаа Б.Сүхбат ЧД-н Засаг дарга, нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга, БГД, Налайх дүүргийн дарга нартай хамтран Япон улсын Шизоуко хоттой 2017 оны 03-р сард хамтран ажиллах гэрээ байгуулж туршлага судалж ирсэн.

Дүүргийн иргэдийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлд дүүргийн хэмжээнд 2016 онд гарсан зам тээврийн осол хэргийн нөхцөл байдлыг танилцууснаар хороо бүрд 5 хүний бүрэлдэхүүнтэй “Урьдчилан сэргийлэх” багийг бүрдүүлж зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн байгууллагыг татан оролцуулж хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн. Чингэлтэй дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 10:00 цагаас “Энхийн төлөө цогцолбор”-т дүүргийн 19 хороодын урьдчилан сэргийлэх

багийн гишүүдтэй хамтарсан “Амар тайван амьдралын төлөө хамтдаа” зөвлөгөөнийг зохион байгуулсан. Тус зөвлөгөөнд Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга Д.Бат-Эрдэнэ, Улсын Ерөнхий прокурорын газар, Чингэлтэй дүүргийн Прокурор, Шүүх, Цагдаагийн 1,2-р хэлтэс, Замын цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Гэрбүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн дарга нар хамтран оролцож мэдээлэл хийсэн.

Онцгой байдлын хэлтэстэй хамтран “ Гамшгийн аюулгүй байдлын тухай зарлан мэдээлэх үед хэрхэн хамтран ажиллах ” нүүлгэн шилжүүлэх үед аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар бие бүрэлдэхүүнд сургалт орж дадлага хийсэн болно.

Чингэлтэй дүүргийн Засаг даргатай 2017 онд байгуулсан үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажил үйлчилгээнээс зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хурд хэмжигч, мотоцикль, нөүтбүүк, ширээ сандал, гадна талын тамбар, суурин станц ус цэвэршүүлэгч, гэрэл зургийн аппарат 12ш, телевиз зэрэг 19 төрлийн тоног төхөөрөмжийг авах асуудлыг шийдвэрлүүлж, дүүргээс худалдан авах тендрийн ажиллагааг зохион байгуулж, тендерт “Гольден прогресс”ХХК-иас компьютер-5, принтер-3, notebook-1, чанга яригч-2, ширээ-2, шкаф-2, сандал-12, хөшиг-5, мотоцикль-2, ус цэвэршүүлэгч-2 ширхэг, зургийн аппарат-12, хурд хэмжигч төхөөрөмж зэрэг нийт 40 сая төгрөгний эд зүйлсийг авч алба хаагчдад хуваарилан өгч, 9,8 сая төгрөгөөр Барилга байгууламжийн аюулгүй байдал, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах үүднээс хэлтсийн байрны гадна талд 2017 оны 07 дугаар сард 2*4 хэмжээтэй өргөтгөлийг шинээр барьсан.

Түгжрэлийг бууруулах ажлын хэсгийн ахлагч н.Баярхүү, Чингэлтэй дүүргийн засаг дарга Ж.Эрдэнбат, Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын газрын дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Эрдэнэбат нарт Бөмбөгөр худалдааны төв орчмын замыг шинээр зохион байгуулах саналыг танилцуулснаар Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээний компанитай хамтарч Алтжин худалдааны төвийн урд замын зорчих хэсгийн өргөтгөсөн. Нийслэлийн Автозамын хөгжлийн газартай хамтарч 2-р хороо Бэтүб хийдийн зүүн талд шинээр нэг чигийн хөдөлгөөнтэй эко чулуун хавтан бүхий 50 метр автозам шинээр ашиглалтад оруулсан. Чингэлтэй дүүргийн Газрын алба, Цагдаагийн 1-р хэлтэс, Үйлдвэр үйлчилгээний хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар,Тохижилт үйлчилгээний газартай хамтарч “Найман шарга” худалдааны төвийн урд шороон зогсоолын талбайд гар дээрээс зөвшөөрөлгүй худалдаа эрхэлдэг байсан иргэдийн лангууг буулгаж, түүхий эд авах, хогийн цэгийг нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулсан.

Чингэлтэй дүүргийн 2 дугаар хороо Урт цагааны урд талын 2 зогсоолын талбай эвдэрч муудсан байсныг засаж сайжруулах саналыг Чингэлтэй дүүргийн Засаг даргад танилцуулж хөрөнгийг шийдвэрлүүлж зогсоолын талбайг эко чулуун хавтангаар шинэчилсэн.

Чингэлтэй дүүргийн цэцэрлэгүүдийн дунд зохион байгуулах Замын хөдөлгөөний цагаан толгой-2017 тэмцээнийг зохион байгуулах талаар Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газрын даргад 2017 оны 4 дүгээр сарын 20 өдөр танилцуулж шаардагдах хөрөнгийг шийдвэрлүүлж, 2017 оны 04-р сарын 27-ны өдөр зохион байгуулсан.

Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны Засаг дарга, Урьдчилан сэргийлэх багтай уулзаж “Амар тайван амьдралын төлөө” 2 сарын аяны хүрээнд 2017 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс 2017 оны 05 дугаар сарын 24-нийг хүртэл 1 сарын хугацаатай хамтарч ажиллахаар болж 23 дугаар сургуулийн бага ангийн 400 хүүхдэд замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, замын хөдөлгөөнд зөв оролцох дадал эзэмшүүлэх сургалтуудыг зохион байгуулах хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажиллахаар төлөвлөж аяны хүрээнд Хүүхэд зорчигчийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах талаар Чингэлтэй дүүргийн Засаг даргаар захирамж гаргуулж 2017 оны 04-р сарын 26-ны өдөр Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 23 дугаар сургуулийн 400 хүүхдэд 1 цагийн сургалтыг зохион байгуулсан.

Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/11 дүгээр захирамж, Чингэлтэй дүүргийн Онцгой комиссын даргын 07 тоот захирамжийн дагуу дүүргийн хэмжээнд 2017 оны 05 дугаар сарын 11, 12-ны өдрүүдэд зохион явуулсан гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулилтад Чингэлтэй дүүрэгдэх Замын цагдаагийн хэлтсийн бие бүрэлдэхүүн бүрэн хамрагдаж Нийслэлийн онцгой байдлын газар болон Нийслэлийн цагдаагийн газраас ирсэн мэргэжилтнүүдэд гамшгийн үеийн нөхцөл байдлыг үнэлж зохион байгуулсан ажлаа шалгуулж 93,7% буюу маш сайн үнэлгээ авсан.

Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлд Зуслангийн замд хурдны мэдээлэх электрон самбар 2 ширхэгийг байрлуулах саналыг хүргүүлснээр 800.000 төгрөгний хөрөнгийг шийдвэрлүүлж 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс Чингэлтэй дүүрэг 19-р хороо 117-р сургуулийн баруун замд байрлуулан зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажилд ашиглаж байна.

Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газрын даргын 2017 оны 05 дугаар сарын 22-ны А/165 дугаар тушаалаар “Бид сайн сайханд дагуулна” уриатай иргэдийн баярын арга хэмжээг 2017 оны 05 дугаар сарын 27-ны өдөр 09:00 цагаас 18:00 цагийн хооронд Тусгаар тогтнолын талбайд зохион байгуулсан. Уг арга хэмжээнд Чингэлтэй дүүрэг дэх Замын цагдаагийн хэлтсээс 2 алба хаагч оролцож, Замын цагдаагийн албанаас хийж хэрэгжүүлж байгаа ажил, цаашид хийхээр төлөвлөж байгаа ажлын талаар иргэд олон нийтэд танилцуулж, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх самбар байрлуулж, иргэдээс албаны үйл ажиллагаатай холбоотой санал авч, зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх 13 төрлийн 350 ширхэг тараах материал, гарын авлагыг иргэдэд тарааж ажилласан. Өдөрлөгийн хүрээнд СУИС-ийн зүүн урд уулзвараас Анкарагийн гудамж, Тусгаар тогтнолын талбайн 3 талын замыг 06:00 цагаас 18:00 цагийн хооронд хааж “Бид бүгдээрээ хөгжимчин” уралдааны авьяаслаг хүүхдүүд, “Бидний бахархал” ардын урлагийн наадмын тэргүүн байр эзэлсэн сургууль, цэцэрлэгүүдийн хүүхэд багачууд, ахмад настны төлөөлөл “380 гаруй ахмад настан, дүүргийн удирдлага иргэд гээд нийт 1500 гаруй хүмүүс баярын жагсаалаар СУИС-аас эхлэн Анкарагийн гудамжаар явсаар Тусгаар тогтнолын талбай хүртэл алхаж урлагийн тоглолтоор үргэлжилсэн. Арга хэмжээний хүрээнд хэлтсээс замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хамгаалалт зохицуулалтад 8 цэгт 10 алба хаагч 2 автомашинтайгаар ажилласан.

Нийслэлийн Засаг даргын “Нийслэл хотоос мал бүхий иргэдийг нүүлгэн шилжүүлэх” тухай захирамжийн дагуу Чингэлтэй дүүргээс 17, 19 дүгээр хорооны мал бүхий 38 өрхийн судалгааг гаргаж, 2017 оны 08 дугаар сарын 14-ний өдөр 13:00 цагаас 15:30 цагийн хооронд дүүргийн 19 дүгээр хорооны Иргэний танхимд Улаанбаатар хотын ерөнхий менежер н.Гантөмөрөөр ахлуулсан ажлын хэсэгтэй ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч Ц.Чинзориг хамтран дээрх мал бүхий иргэдтэй уулзаж Нийслэлийн Засаг даргын захирамжийг танилцуулж иргэдийн санал хүсэлтийг сонсож хамтарч ажилласан.

Чингэлтэй дүүрэг дэх замын цагдаагийн хэлтсээс 09 дүгээр сарын 21-ний өдөр Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд чингэлтэй дүүргийн эдийн засаг, нийгмийн 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд тусгах ажлын саналыг хүргүүлсэн.

Дүүргийн онцгой байдлын хэлтэс, мэргэжлийн хяналтын газартай хамтран “Шүлхий, Цэцэг өвчин” нэгдсэн арга хэмжээг зуслангийн замд 2017 оны 09 дүгээр сарын 28-ны өдрөөс 10 дугаар сарын 02-ны өдрийн хооронд зохион байгуулсан. Тус арга хэмжээнд 3 алба хаагч ажилласан. Мөн “Тарваган тахал” нэгдсэн арга хэмжээнд цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч Ц.Оргил-Өөд ажилласан.

Дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс санхүүжилтээр “Алкоблов” согтуурлыг тогтоогч тандагч 2 ширхэг багажийг туршилтын журмаар шөнийн эргүүд үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдад ашиглуулж байна. Тухайн багаж нь хуучин тандагчтай харьцуулахад 2 секундээр удаан согтуурлыг зэргийг тогтоодог боловч олон

улсын стандарт хэмжилзүйн шаардлага хангасан багаж бөгөөд нэг бүрийн үнэ 1.150.000 төгрөгөөр зах зээлд худалдаалагддаг.

Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудын 1-5 дугаар ангийн сурагчдын дунд “Ногоон гэрэл-Цагаан шугам 2017” тэмцээнийг Чингэлтэй дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын салбар зөвлөл, Улаан загалмайн нийгэмлэгтэй хамтран 2017 оны 10 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 49 дүгээр сургуулийн спорт зааланд зохион байгуулсан. Тус тэмцээнд ерөнхий боловсролын нийт 15 сургууль оролцож, тэргүүн байранд 117 дугаар сургууль, дэд байранд 72 дугаар сургууль, гуравдугаар байранд 49 дүгээр сургууль тус тус шалгарсан. 11 дүгээр сарын 28-ны өдөр Улсын хэмжээнд зохион байгуулагдсан “Ногоон гэрэл Цагаан шугаам 2017” тэмцээнд 117 дугаар сургууль оролцож Гуравдугаар байр эзэлсэн.

Тус хэлтсийн зохицуулагч, цагдаагийн ахмад У.Батбаяр, цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлагч Ж.Мөнхтулгын хамт Нийслэлийн Засаг Даргын 2017 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/679 тоот захирамжийн дагуу 2017 оны 10 дугаар сарын 20-ноос 22-ны өдрийг хүртэл Чингэлтэй дүүргийн 24 дүгээр сургууль дээр байрлах цэрэг татлагын товчоонд ажилласан.

Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт байрлах хяналтын камеруудыг нэгтгэн хэлтсийн байранд нэг хяналтын серверийн өрөөтэй болгох талаар хэлтсийн дарга, ахлах зохицуулагч нар 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газрын Олон нийттэй харилцах хэлтсийн даргыг хүлээн авч уулзсан.

Зам тээврийн хөгжлийн яам, Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн газар, ХСИС-ын, ШУТИС-ын Тээврийн сургууль, Чингэлтэй дүүргийн 13, 14, 15, 16 дугаар хороотой хамтран “Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх кампанит ажил” сэдэвт арга хэмжээний нээлтийн арга хэмжээг 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 72 дугаар сургууль дээр зохион байгуулсан.

е. Байгууллагын удирдлагад хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн талаар:

Засгийн газрын 11-11 төвд иргэд, байгууллагаас Чингэлтэй дүүрэг дэх замын цагдаагийн хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн 51 смарт, иргэдээс зөрчлийн шинжтэй ирүүлсэн 39 өргөдөл нийт 90 гомдол мэдээллийг хүлээн авч заасан хугацаанд шийдвэрлэж, өргөдөл гаргасан иргэн, албан тушаалтанд хэрхэн шийдвэрлэсэн талаар танилцуулан ажилласан.

ё. Нэвтрүүлсэн шинэлэг ажил, арга хэмжээ:

Тус хэлтсээс 2017 оны 01 дүгээр сард алба хаагчдын ар гэрээр орж, ахуй амьдралтай танилцах, судалгаа гаргах зорилгоор гаргасан төлөвлөгөөний дагуу хэлтэс, тасгийн дарга нар, офицеруудын, ахлах зохицуулагч нар цагдаа нарын ар гэрээр орж ахуй амьдралтай нь танилцаж судалгаа гаргасан. Нийт алба хаагчдын 27 буюу 50,9% нь орон сууцанд, 20 буюу 37,7% нь хашаа байшинд, 6 буюу 11,3% нь түрээсийн орон сууц, хашаа байшинд тус тус амьдарч байна. Үүнээс 48 буюу 81,2% нь орон сууц, хашаа байшин, автомашин болон цалингийн зээлтэй байна. Амьдралын баталгаажих түвшингээс доогуур орлготой 7 албан хаагч байгаа нь нийт алба хаагчдын 13,2 хувийг, иргэний бүртгэлийн хаягтай оршин суух хаягийн зөрүүтэй 16, гэрлээгүй 12, автомашинтай 22 алба хаагч тус тус байна. Мөн хэлтсийн алба хаагчдаас дотооддоо удаа дараа зөрчил заагдсан, гадны нөлөөнд автах магадлалтай алба хаагчдын судалгааг гаргаж, 2017 оны 05 сарын 31-ний өдөр ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч Ц.Чинзориг ЗЦА-ны Сэтгэл зүйч, цагдаагийн ахмад Э.Бямбажаргалын хамт 3 зохицуулагчийн гэрээр, ахлах зохицуулагч, цагдаагийн

ахмад Б.Зоригт 3 цагдаагийн ар гэрээр орж гэр бүлийн гишүүдтэй уулзаж, ахуй амдралын талаар судалгааг гаргасан, анхаарал татсан зөрчил гаргаж болзошгүй нэр бүхий 5 цагдаа зохицуулагчийн ар гэрээр зохицуулагч нарыг оруулж тэдний гэр бүлийнхэнтэй уулзаж, ахуй амьдралын талаар судалгаа авч, тэднээс гаргасан саналыг нэгтгэн 2 удаа Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын газрын даргад танилцуулсан бөгөөд алба хаагчдын ар гэрийн гишүүдээс гаргасан саналын мөрөөр Зуслангын газар олгуулах хүсэлтийг Чингэлтэй дүүргийн Засаг даргад хүргүүлсэнээр нэр бүхий 32 алба хаагчид 17 дугаар хорооны нутагт 0,7 га газрыг өмчлүүлэхээр шийдвэрлүүлсэн мөн 1 алба хаагчийг Залуу гэр бүлийг дэмжих “Аз жаргалын эрэлд” төслийн уралдаан тэмцээнд оролцуулан дэмжиж 2 өрөө байраар шагнуулсан, 1 алба хаагчийг дүүргийн хөдөлмөрийн аваргад тодохойлуулж өргөмжлөл 1 сая төгрөгөөр шагнуулсан, ЗДТГ-т улмажлан түрээсийн байранд амьдардаг 2 алба хаагчид газар олгуулсан, ЗДТГ-аас 1 алба хаагчид хаашаа байшин барих ажилд дэмжлэг үзүүлэн урамшуулж үр дүнг тооцон ажилласан. Мөн албаны сургалтыг ажлын цагаар хүртээмжтэй байдлаар станцаар зохион байгуулсан.

Хэлтсийн байрны гадна талд Монгол Улсын Төрийн Далбаа, Төрийн Сүлд, Замын цагдаагийн албаны тэмдэг бүхий 3 ширхэг туг мандуулсан.

“Татвар” нэгдсэн арга хэмжээний хүрээнд тус хэлтэс тэргүүн байр эзлэн 1.800.000 төгрөгөөр шагнуулсан бөгөөд 800,000 төгрөгөөр иргэдэд мэдээлэх урсдаг LED самбар худалдан авч хэлтсийн байрны гадна талд байрлуулсан.

Хэлтсээс алба хаагчдын амралт чөлөөт цагийг гэр бүлтэй нь өнгөрүүлэх, ажлын стрессийг бууруулах, халуун дулаан уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор хамт олноо хошуучлан ажилласан алба хаагчдыг гэр бүлийн гишүүдийн хамт Маск продакшны хошин шог, Single lady-3 зэрэг 6 удаагийн урлаг соёлын арга хэмжээ үзүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулж давхардсан тоогоор 42 алба хаагчийг гэр бүлийн гишүүдийн хамт хамруулаад байна.

Хэлтэст ажиллаж байсан үе үеийн ахмад ажилтан, одоо ажиллаж байгаа алба хаагчдын дүрийг мөнхжүүлэх зорилгоор зургийн цомогтой болох ажлыг зохион байгуулж эхлүүлээд байна.

Албаны үйл ажиллагааг сайжруулах эзэн, холбогдогч нь тогтоогдохгүй зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч Ц.Чинзоригийн өгсөн үүргийн дагуу хороо хариуцсан зохицуулагч нар өөрийн хариуцсан хорооны нутаг дэвсгэрт байрлах аж ахуйн нэгж, албан байгууллагын гадна талын камерын судалгааг гаргаж Теле камер, цахим зөрчил хариуцсан зохицуулагч, цагдаагийн дэслэгч Л.Тэгшжаргал нэгтгэн ажилласан.

Хэлтсийн алба хаагчдын хоорондын харилцааг сайжруулж зөв хандлагыг төлөвшүүлэх үүднээс эрдэмтэн судлаачдын хэлсэн 30 орчим ишлэлийг хэлтсийн 1,2 дугаар давхарт байршуулаад байна.

Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах хяналтын камеруудыг нэгтгэн хэлтсийн байранд нэг хяналтын серверийн өрөөтэй болгож өгөх хүсэлтийг Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газарт хүргүүлснээр камерын хяналтын өрөөний засварын ажлыг 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлүүлээд байна.

ж. Судалгаа дүн шинжилгээ хийсэн ажлын талаар:

Дүүргийн нутаг дэвсгэрт 2016, 2017 онд зам тээврийн ослын улмаас хүний амь нас хохирсон, гэмтсэн ослын шалтаан нөхцөлийн судалгааг эхний 10 сарын байдлаар гаргасан. Дээрх судалгааг үндэслэн дүүргийн нутаг дэвсгэрт Тээврийн хэрэгслийн гадна талын гэрэлтүүлэх хэрэгсэл”, “Тусгай дуут гэрэл дохио”, “Хүүхэд аюулгүй орчин”, “Улсын дугаар”, “Илрүүлэлт”, “Ачааны автомашин”, “Улсын дугаар”, “Нийтийн тээвэр”, “Тээврийн хэрэгслийн эвдрэл гэмтэл” “Татвар”, “Ачааны автомашин” “Тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах ялын хэрэгжилт” хоёр сарын аяны зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга

хэмжээний үед, гудамж замд хяналт шалгалтаар нийт 3329 хүнийг 68.856.200 төгрөгний торгуулийн шийтгэл ногдуулж, ажилласан. “Мөн хяналт шалгалтыг төрөлжүүлэн хамгаалах бус, зогсолт, зогсоол, эгнээ байр, хүн, ачаа тээвэр, бүрэн бус, ачааны автомашин, нийтийн тээвэр зэргээр төрөлжүүлэн өдөр бүр зохион байгуулах ажлын үүрэг чиглэл өгч, үр дүнг тооцон ажилласан. Мөн хэлтсийн хэмжээнд бүсийн нутаг дэвсгэрт “Зуслан хяналт шалгалт”, “Зогсох зогсоол дэг журам”, “Хурд”, “замын хөдөлгөөний сахилга соёл 2017”, “ил автомашин худалдаа, ил авто угаалга” зэрэг хэсэгчилсэн 8 арга хэмжээг зохион явуулж цагдаагийн нийтлэг үүргээр 51, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 198, зөрчил гаргасан 1525 жолоочийг 41.175.000 төгрөгөөр торгох арга хэмжээ авч ажилласан. Хэсэгчилсэн арга хэмжээний үр дүнг энэ оны эхний 10 сарыг өмнөх оны мөн үетэй харьцуулан үзэхэд:

Зөрчлийн илрүүлэлт 89304 буюу 46,1%-иар, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 2275 буюу 14,7%-иар тус тус өссөн, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 35,2%-иар, зам тээврийн ослын улмаас хүний амь нас хохирсон хэрэг 2016 онд 10, 2017 онд 10 буюу 0%-иар, гэмтсэн хүн 39,5%-иар, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 42,6%-иар тус тус буурсан үр дүн гарсан байна

3. Бусад:

Алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хэлтсийн дарга, ахлах зохицуулагч нар алба хаагчдын, ар гэрээр орж, ахуй амьдралтай танилцаж судалгаа гаргах хуваарийг гаргаж 2017 оны 01 сарын 04-нөөс 2017 оны 01 сарын 10-ны өдрүүдэд хэлтсийн дарга, ахлах зохицуулагч нар хэрэг бүртгэгч, зохицуулагч, цагдаа зохицуулагч нарын ар гэр ахуй амьдралтай нь танилцаж, тэднээс гаргаж байгаа санал хүсэлтийг сонсож 12 төрлийн судалгаа авсан. Нийт алба хаагчдын 27 буюу 50,9% нь орон сууцанд, 20 буюу 37,7% нь хашаа байшинд, 6 буюу 11,3% нь түрээсийн орон сууц, хашаа байшинд тус тус амьдарч байна. Үүнээс 48 буюу 81,2% нь орон сууц, хашаа байшин, автомашин болон цалингийн зээлтэй байна. Амьдралын баталгаажих түвшингээс доогуур орлоготой 7 албан хаагч байгаа нь нийт алба хаагчдын 13,2 хувийг, иргэний бүртгэлийн хаягтай оршин суух хаягийн зөрүүтэй 16, гэрлээгүй 12, автомашинтай 22 алба хаагч тус тус байна. Алба хаагчдаас дотооддоо удаа дараа зөрчил заагдсан, гадны нөлөөнд автах магадлалтай алба хаагчдын судалгааг гаргаж, 2017 оны 05 сарын 31-ний өдөр ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч Ц.Чинзориг ЗЦА-ны Сэтгэл зүйч, цагдаагийн ахмад Э.Бямбажаргалын хамт 3 зохицуулагчийн гэрээр, ахлах зохицуулагч, цагдаагийн ахмад Б.Зоригт 3 цагдаагийн ар гэрээр орж гэр бүлийн гишүүдтэй уулзаж ярилцсан. Мөн анхаарал татсан сахилга ёс зүйтэй холбоотой зөрчил гаргаж болзошгүй нэр бүхий 5 цагдаа зохицуулагчийн ар гэрээр зохицуулагч нарыг оруулж тэдний гэр бүлийнхэнтэй уулзаж, ахуй амьдралын талаар судалгаа авч, тэднээс гаргасан саналыг нэгтгэн 2017 оны 08 дугаар сарын 16-ны өдөр Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын газрын даргад танилцуулсан. Алба хаагчдыг сэтгэл зүйн хямралаас үүдэлтэй сэтгэл гутрал, уур бухимдлаас салгах үүднээс 2017 оны 01 сард нэг бүрчлэн, дотооддоо удаа дараа зөрчил заагдсан, гадны нөлөөнд автах магадлалтай нэр бүхий 6 алба хаагчийн ар гэрээр 2017 оны 05 дугаар сард, иргэдтэй зүй бус харьцсан, харилцааны доголдол гаргасан 3 алба хаагчтай 2017 оны 11 сард тус тус Замын цагдаагийн албаны сэтгэл зүйч цагдаагийн ахмад Э.Бямбажаргалыг урьж нийт 3 удаа алба хаагчидтай нэг бүрчлэн ганцаарчлан болон тэдний гэр бүлийн гишүүдтэй уулзуулж сэтгэл зүйн зөвлөгөө өгүүлэх зэрэг ажлыг зохион байгуулсан. Мөн алба хаагчдын гэр бүлийн гишүүдтэй 2017 оны 01 сарын 28, 09 сарын 08-ны өдрүүдэд хэлтсийн хурлын зааланд 2 удаа уулзалт зохион байгуулж, хэлтсээс алба хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн асуудлыг сайжруулах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажил, цаашид хийхээр төлөвлөж байгаа ажлын талаар товч танилцуулж, албаны үйл ажиллагаатай холбоотой санал хүсэлтийг сонсож харилцан ярилцсан. Хэлтсийн алба хаагчдын гэр бүлийн гишүүдийн төлөөлөл болгож “Гэр бүлийн гишүүдийн зөвлөл”-ийг 5 хүний бүрэлдэхүүнтэй

байгуулсан. Гэр бүлийн гишүүдээс гаргасан санал хүсэлтийг нэгтгэж НЗХХГ-ын даргад танилцуулгаар 2 удаа хүргүүлсэн. Уулзалтын үеэр гэр бүлийн гишүүдэд “Их тайга” ххк-ний Их тайга гарын бэлгийн багцийг өгч, хэлтсийн алба хаагчдыг хөгжүүлэх өрөөнд ширээний теннис тоглох, үдийн хоол зэрэг арга хэмжээг зохион байгуулсан. Дээрх арга хэмжээнд давхардсан тоогоор 76 гэр бүлийн гишүүд хамрагдсан.

Уламжлалт Сар шинийн баярыг тохиолдуулан тус хэлтсийн ахмад ажилтнуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэн Их тайга компаний гарын бэлэг өгөх ажлыг зохион байгуулсан. Мөн 10 ахмад ажилтанг ахмадын амралтын газар сувилалд амраасан. Ахмадын баярын өдрийн тохиолдуулан ахмад ажилтангуудын хүлээн авч гарын бэлэг гардуулсан.

Самбуугийн гудамж Гал унтраах 10-р ангийн зүүн талд байрлах “Өнгөлөг “ авто угаалгын газрын захиралтай уулзаж, хамтран ажиллаж тус угаалгын газарт албаны автомашинуудыг хөнгөлөлттэй үнээр буюу 6000 төгрөгөөр угаалгаж байна.

Цэргийн баярын өдрийг тохиолдуулан 2017 оны 03 сарын 18-ны өдөр Эрх чөлөөний талбайд Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газар, Онцгой байдлын хэлтсээс зохион байгуулсан өдөрлөгийн үеэр хэлтсийн цагдаа зохицуулагч, цагдаагийн дэд ахлагч О.Баярхүүг Чингэлтэй дүүргийн “Хөдөлмөрийн алдар” тэмдгээр шагнуулсан.

Чингэлтэй дүүргийн Засаг даргын орлогч Ж.Чимэдцогзолтой хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Сүхбат уулзаж Засаг даргатай 2017 онд байгуулсан үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажил үйлчилгээнээс материаллаг бааз бэхжүүлэх ажилд шаардлагатай 40 сая төгрөг, хэлтсийн байрны үүдний хэсэгт өргөтгөл хийх ажилд зарцуулагдах 10 сая төгрөгний хөрөнгө зэргийг шийдвэрлэж Чингэлтэй дүүрэг үүсэн байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан 2017 оны 07 сард хийж гүйцэтгэсэн.

Чингэлтэй дүүрэг 19-р хороо Жигжидын зуслангийн уулзварт байрлуулсан зөөврийн хяналтын постны өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор постны гадна талыг будаж цацруулагч наалт шинээр нааж, ажиллахгүй байсан мегальк, хяналтын камерыг засаж хэвийн ажиллагаанд оруулсан.

Баянбүрийн постны /614/ гадна талын өнгө үзэмжийг сэргээх зорилгоор бүтэн угааж өнгө үзэмжийг сайжруулсан.

Бүх нийтийн мод тарих аяны хүрээнд Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 31 дүгээр цэцэрлэгийн хашаанд хэлтсээс 9 ширхэг бургас мод тарьсан

Хэлтийн дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Сүхбат Төв аймгийн Батсүмбэр суманд байрлах Замын цагдаагийн албаны ногооны талбайд алба хаагчдад зориулсан байшин барих ажлыг зохион байгуулсан.

Алба хаагчдын томилгоотой холбоотой шилжсэн алба хаагчдын нэрсийг авч, шинээр томилогдсон алба хаагчдын нэрсээр сольж, өрөөнүүдийн хаягыг шинэчилсэн.

Хэлтсийн байрыг цэцэгжүүлэх үүднээс 10 төрлийн 25 ширхэг цэцэг худалдан авч, алба хаагчдын өрөө болон хэлтсийн байрны 1, 2 давхарт байрлуулсан.

Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан хугацааны цолоор офицер 1, цагдаа 4 гэсэн нийт 5 алба хаагчийг шагнуулсан.

Киа рио маркийн 0641 УНУ улсын дугаартай автомашины LED гэрлэн мигальк ажиллахгүй байсныг зассан.

Зөөврийн постны хяналтын камерыг тогтоогч суурь хөл хугарсан байсныг засаж хэвийн ажиллагаатай болгосон.

Албаны Хьюндай аксент маркийн 0229 УБУ, Киа рио маркийн 0651 УНУ улсын дугаартай автомашинуудыг эвүүртэй болгож 2017 оны 08 дугаар сарын 04-ний өдөр ЦЕГ-ын Автобааз дээр Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын мэргэжилтэнд шалгуулсан.

Киа рио маркийн 06-41 УНУ, 06-40 УНУ, 06-51 УНУ улсын дугаартай автомашинуудын өвлийн дугуйг сольсон мөн 06-41 УНУ, 06-40 УНУ, 06-51 УНУ улсын дугаартай автомашинуудын засвар үйлчилгээг авто бааз дээр хийлгэж амартизатор, пүрш, явах эд ангиудыг солиулах ажлыг зохион байгуулсан.

Мөн албаны автомашины бүрэн бүтэн байдлыг хангах үүднээс хэлтсийн 8 автомашиныг ЦЕГ-ын автобааз дээр 2017 оны 08 дугаар сарын 10-наас 09 дүгээр сарын 30-ныг хүртэл ээлжит засвар үйлчилгээнд оруулж өвлийн дугуй, өвлийн тос масло, урд хойд амиртизаторыг солиулсан. 2017 оны 11 дүгээр сарын 11,12-ны өдрүүдэд Хөсөг трейд авто тээврийн төвд албаны 8 автомашиныг оношлогоонд оруулсан. Алба хаагчдын техник хэрэгслийг боловсронгуй болгох шинэ дэвшилтэт технологийг ашиглах үүднээс 4 сая төгрөгний үнэ бүхий "DRONE" буюу нисдэг камер, 14 сая төгрөгний үнэ бүхий зөөврийн "EWIG HD 3000-E" маркийн хурд хэмжигч, Зам тээврийн ослын дуудлаганд түргэн шуурхай очиж ажиллах үүднээс нэг бүрийн 3,5 сая төгрөгний үнэ бүхий 2 ширхэг мотоцикль, зам тээврийн ослын үед хэргийн газарт нотлох баримтыг бэхжүүлэх зорилгоор 12 ширхэг зургийн аппарат зэргийг Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газраас шийдвэрлүүлэн үйл ажиллагаандаа хэрэглэж байна.

**Хоёр. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах,
олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:**

а. Цагдаагийн нийтлэг үүргийн чиглэлээр:

Чингэлтэй дүүргийн 6 дугаар хорооны нутаг Тасганы овооны замд 2017 оны 08 дугаар сарын 25-наас 26-нд шилжих шөнө 00:05 цагийн үед явган зорчигч 57 настай "Э"-г марк улсын дугаар тодорхойгүй автомашинаар мөргөж амь насыг нь хохироож ослын газраас зугтаасан хэргийг зохицуулагч, цагдаагийн дэслэгч Л.Тэгшжаргал, цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлагч, О.Баярхүү, В.Эрдэнэдаваа нар шуурхай эрэн сурвалжилж 2017 оны 08 дугаар сарын 27-ны өдөр Сүхбаатар дүүргийн нутаг "Авто плаза"-гийн хойд талын 46 дугаар байранд оршин суух Т.Камри маркийн 01-88 УНР улсын дугаартай тээврийн хэрэгслийн жолооч Б.Энхзаяа үйлдсэн болохыг олж тогтоож ЗЦА-ны Гэмт хэрэгтэй тэмцэх газрын эрүүгийн хэргийн мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч н.Ихбаярт хүлээлгэн өгсөн.

Чингэлтэй дүүргийн 16 дугаар хороо Согоотын 66-897 тоотод оршин суух иргэн Я.Алимаагийн гэрээс 2017 оны 06 дугаар сарын 11-нээс 12-нд шилжих шөнө Самсунг брендийн 42 инчийн LCD телевизор, ACER брендийн суурин компьютер алдагдсан хулгайн хэргийн холбогдогч Батсүхийн Батбаатарыг 2017 оны 08 дугаар сарын 25-ны өдөр цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч Б.Алтан-Эрэг Чингэлтэй дүүргийн цагдаагийн 2 дугаар хэлтсийн эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Ц.Мөнхбаттай хамтарч Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэр Шарга морьтын автобусны буудал орчмоос, цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлагч Б.Мягмарсүх 2017 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо Шадивлангийн замд Х.Соната 6 маркийн 79-30 УНН улсын дугаартай тээврийн хэрэгслийн жолооч Оросоогийн Баярмагнай нь гарал үүслийн бичиггүй 4 шуудай буюу 200 орчим кг цайруулсан самар тээвэрлэж явсаныг тус тус саатуулж Чингэлтэй дүүргийн цагдаагийн 2 дугаар хэлтэст хүлээлгэн өгсөн. Цагдаагийн нийтлэг үүргийн чиглэлээр 3 гэмт хэрэг, нийтлэг үүргийн 101 зөрчил илрүүлж холбогдох байгууллага албан тушаалтанд шилжүүлсэн байна.

б. Хэрэг бүртгэх албаны чиглэлээр:

Дүүргийн нутаг дэвсгэрт гарсан зам тээврийн осол хэргийн шинжтэй 318 материалыг хүлээн авч 210 материалыг шийдвэрлэж харьяаллын дагуу шилжүүлсэн 17, хэрэгсэхгүй болсон 2, зөрчлийн хэрэг үүсгэхээс татгалзсан 2, бусад 87 ослын материалд зөрчлийн хэрэг нээж, хуулийн хугацаанд шалгаж байна.

Иргэд байгууллагаас зам тээврийн хэрэг, ослын шинжтэй нийт 39 өргөдөл хүлээн авч хуулийн хугацаанд шалгаж байна.

Зөрчлийн тухай хуулийн 14.7.3.1 дэх заалт зөрчин согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 2561 зөрчлийн материал хүлээж авснаас хялбаршуулсан журмаар 2495 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хас ч, харьяаллын дагуу 8, хэрэгсэхгүй болсон 3, татгалзсан 1 үлдэгдэл 54 материалыг хялбаршуулсан журмаар болон зөрчлийн хэрэг нээж шийдвэрлэхээр ажиллаж байна.

Зөрчлийн тухай хуулийн 14.7.1 дэх заалтыг зөрчсөн 314 жолоочид холбогдох материалыг хүлээн авснаас зөрчлийн хэрэг нээсэн 2, хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ авагдсан 302, харьяаллын дагуу шилжүүлсэн 4, үлдэгдэл 6 материалыг хуулийн хугацаанд нь шалгаж шийдвэрлэж байна.

Зөрчлийн хэрэг нээсэн 191 материалаас зөрчлийн тухай хуулийн 14.7.5 дах заалтын зөрчилтэй 110 иргэнд холбогдох материалыг хүлээн авч 103 иргэнийг шүүхийн шүүгчийн тогтоолоор 7-30 хоног баривчлуулж, зөрчлийн хэрэг үүсгэхээс татгалзсан 1, хэрэгсэхгүй болсон 2, харьяаллын дагуу шилжүүлсэн 2, үлдэгдэл 2 иргэнд холбогдох материалыг хуулийн хугацаанд шалгаж байна.

в. Замын цагдаагийн албаны чиглэлээр:

Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг ослоос урьдчилан сэргийлэх, гудамж замын хөдөлгөөнд тавих хяналт зохицуулалтыг эрчимжүүлэх, хөдөлгөөнд оролцогчдын сахилга соёлыг дээшлүүлэх чиглэлээр гудамж замд хийсэн хяналт шалгалтаар нийт 107107 зөрчил илрүүлснээс Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн заалт зөрчин согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 2383, мөн хуулийн 14.7 зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчилтэй 297, тээврийн хэрэгслийг түр саатуулан журамлан улсын дугаарын хязгаарлалт 251, бүрэн бус 7295, хамгаалах бүс хэрэглээгүй 11366, хориглосон нөхцөлөөр зогссон 24198, хүн ба ачаа тээвэрлэх журам зөрчсөн 1455, эгнээ байр буруу эзэлсэн 6651 нийт 99241 жолоочийг 2.701.375.070 төгрөгөөр торгосон. Замын цагдаагийн алба болон бусад албадаас зарлагдсан 163 дугаарыг илрүүлэн ерөнхий жижүүрт хүлээлгэн өгсөн байна. Цагдаагийн нийтлэг үүргийн дагуу 122, АСАП санд эрэн сурвалжлагдаж байсан 72 иргэнийг илрүүлж харьяаллын дагуу холбогдох байгууллага албан тушаалтанд шилжүүлэн ажилласан.

Мөн дүүргийн нутаг дэвсгэрийн алслагдсан гудамж замууд болох Хайлааст, Чингэлтэй, Зуслангийн замуудад 2 алба хаагчийг хөдөлгөөнт байдлаар хяналт шалгалт хийлгэж, зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна. Баянбүрдийн тойргийн байнгын пост /614/-нд 3 алба хаагчийг 08:00-16:00, 16:00-08:00 цаг хүртэл 3 ээлжээр үүрэг гүйцэтгүүлэн ажиллаж байна.

Тус хэлтсээс 2017 оны 09 сарын 20-ноос 10 дугаар сарын 29-ныг хүртэл “Улсын дугаар” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Энэ арга хэмжээний хүрээнд тээврийн хэрэгслийн улсын дугаар бүдгэрсэн, улсын дугаарын тоон дээр боолт боосон, тороор халхалсан, улсын дугаар буруу байрлуулсан, улсын дугаар зүүгээгүй зөрчилтэй тээврийн хэрэгслийг зогсоон шалгаж зөрчлийг фото зургаар баримтжуулан авч зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллаж байна.

Замын цагдаагийн албанаас зохион байгуулж буй “Ачаа тээвэр”, Татварын Ерөнхий газартай хамтран зохион байгуулж буй “Татвар” нэгдсэн арга хэмжээг 2017 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэл Хүнсний 1 дэлгүүрийн зүүн уулзвар / пост-620/, Баянбүрдийн тойрог /пост--614/, Зуслангийн замд /пост-627/ постонд татварын байцаагч нартай хамтран ажиллаж байна.

**г.Цахим зөрчил илрүүлэлт, шийдвэрлэлтийн
чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил:**

Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт ЗХД-ийн 11 дүгээр зүйл 11.5 дахь заалтыг зөрчиж зорчих хэсгийн 1 дүгээр эгнээ болон бусад хориглосон газарт зогссон 25347 тээврийн хэрэгслийн гаргасан зөрчлийг фото зургаар баримтжуулан ЗХУТ-д файлаар хүргүүлэн тухайн тээврийн хэрэгслийн эзэмшигчийн гэрийн хаягаар торгуулийн хуудсыг хүргүүлэн ажиллаж байна. Мөн Фото зургийн зөрчил дээр ЗДТГ-аас 3 урамшуулалт эргүүлийг ажиллуулж, ахлах зохицуулагч нар өдөр тутмын үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байна.

д. Нийтийн хэв журам хамгаалах албаны чиглэлээр:

Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын газрын даргын баталсан хуваарь төлөвлөгөөний дагуу 13 алба хаагч Сүхбаатарын талбайн зохион байгуулагдсан мөнгөн шөнө арга хэмжээний хамгаалалт, 2017 оны 03 сарын 18-ны өдөр “Цэргийн баяр”-ыг тохиолдуулан жанжин Д.Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөх үед, 2017 оны 03 сарын 23-ны өдөр 15:30-16:30 цагийн хооронд Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулилт зохион байгуулагдах үед, 2017 оны 03 сарын 31-ний өдөр “Оффшорчдыг цээрлүүлье” жагсаал, цуглааны үеийн хамгаалалт, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас зохион байгуулсан “Иргэдэд ойр, эрх зүйн үйлчилгээ” нээлттэй хаалганы өдөрлөг зэрэг арга хэмжээнүүдийн үед Сүхбаатарын талбайн баруун замд 1 пост, Чингэлтэй дүүргийн 5-р хороо Тусгаар тогтнолын талбайд МАХН-ын дарга Н.Энхбаярыг 2017 оны ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлэхгүй талаар Сүхбаатар дүүргийн шүүхээс гаргасан шийдвэрийг эсэргүүцсэн жагсаал, Автомашингүй өдөр, “Улаанбаатар марофон 2017” олон улсын гүйлтийн тэмцээн, Чингэлтэй дүүргээс 2017 оны 05 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан “Иргэдийн баяр”, “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг 2017 оны 06 дугаар сарын 01-ний өдөр тус тус Тусгаар тогтнолын талбайд тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээ, Мөн Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/11 дугаартай захирамж, Чингэлтэй дүүргийн Онцгой комиссын даргын 07 тоот захирамжийн дагуу дүүргийн хэмжээнд 2017 оны 05 дугаар сарын 11, 12-ны өдрүүдэд зохион явуулсан гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулилтын хамгаалалтад, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит болон дахин сонгуулийн үйл ажиллагааны хамгаалалт зохицуулалтад 2017 оны 06 дугаар 26, 2017 оны 07 дугаар сарын 07-ны өдрүүдэд Чингэлтэй дүүргийн 1-19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт нийт 47 хэсгийн хороодын хамгаалалтад, Үндэсний их баяр наадмын Хүчит бөхийн барилдааны үеийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хамгаалалт зохицуулалтад, Үндэсний их баяр наадмын Хурдан морины уралдааны үеийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хамгаалалт зохицуулалтад хэлтсээс Хүй долоон худагт ажиллах 25 алба хаагчдыг ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч Ц.Чинзориг хариуцан 2017 оны 07 дугаар сарын 09-ний 14 цагт Хүй долоон худаг дахь цагдаагийн хүрээнд байрлаж, 2017 оны 07 дугаар сарын 10, 11, 12, 13-ны өдрүүдэд Төв аймгийн Аргалан сумийн нутаг Хүй долоон худгийн Ү, Г, М салдаг уулзвараас баруун тийш Цагаан хөтлийн даваа хүртэл, Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний үед дүүргийн нутаг дэвсгэрт ажиллах 23 алба хаагчийг ахлах зохицуулагч, цагдаагийн ахмад Б.Зоригт хариуцан замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хамгаалалт зохицуулалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагаатай холбогдуулж Сонгуулийн ерөнхий хорооны үүдэнд буюу Тусгаар тогтнолын талбайд зохион байгуулсан 3 удаагийн тайван жагсаалын хамгаалалтад, Сүхбаатарын талбайд 2017 оны 07 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсан “Улаанбаатарын үдэш-2017” арга хэмжээний үеийн хамгаалалт зохицуулалтад, Хүй долоон худагт 2017 оны 07

дугаар сарын 11-ний өдөр 2-р чиглэл, 2017 оны 07 дугаар сарын 12-ны өдөр 1, 2, 3 дугаар чиглэл, Улз-18, Хүрэмт-28, Ганга-22, Цамба-21-ийн зочин, 2017 оны 07 дугаар сарын 13-ны өдөр 2-р чиглэлүүд Үндэсний их баяр наадмын Хурдан морины уралдааныг үзэж сонирхохоор зорчих үеийн, Тулгар төрийн 2226, Их Монгол Улсын 811, Ардын хувьсгалын 963 жилийн ой, Үндэсний их баяр наадмын нээлтийн арга хэмжээ болон хүчит бөхийн барилдааныг үзэхээр Төв цэнгэлдэх хүрээлэнд 1, 2, 3 дугаар чиглэлүүд зорчих үеийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хамгаалалт зохицуулалтад, “Хүрээ цам” даншиг наадмын хамгаалалтад 2017 оны 08 дугаар сарын 05,06-ны өдрүүдэд Хан-уул дүүргийн нутаг Гандийн гудамжинд 8 алба хаагч 1 автомашинтайгаар, Олон Улсын Иргэний Агаарын “ICAO”-ийн байгууллагын Ерөнхийлөгч ноён Olumuyiwa Benard Aliu, Ерөнхий нарийн бичгийн дарга, ноён Fang Liu Arrival тэргүүтэй төлөөлөгчид Төрийн ордноос Гандантэгчлэн хийд орох буцах үед, БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Засаг захиргааны дэд тэргүүлэгч бөгөөд Нийгмийг аюулаас хамгаалах яамны тэнхмийн дарга, Ноён Ма Мин Монгол Улсад айлчлалын үеийн хамгаалалтад, Сүхбаатарын талбайд 10 дугаар сарын 24-ны өдөр “Лантуун дохио” төрийн бус байгууллагаас гэр бүлийн хүчирхийлэлд өртөж төрсөн эцэг, хойд эхийн гарт эмгэнэлтэйгээр амь насаа алдсан 13 настай охин, 5 настай охины хэргийн эсрэг “нүдээ нээ” тайван жагсаалын үед 8 цэгт 9 алба хаагч 2 автомашинтайгаар, 11 дүгээр сарын 01-ний өдөр Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэр Тусгаар тогтнолын талбайд өлсгөлөн зарласан иргэн Т.Энхболд, 4 дүгээр хорооны нутаг дэвсгэр Хэлмэгдэгсдийн хөшөөний урд өлсгөлөн зарласан иргэн Т.Батдэлгэр нарыг албадан эмчилгээнд хамруулах үед 10 цэгт 16 алба хаагч 3 автомашинтайгаар, Сүхбаатарын талбайд 11 дүгээр сарын 10-ны өдөр “Утааны эсрэг аав ээжүүд хамтдаа” тайван жагсаал цуглааны хамгаалалтад зохицуулалтад 6 алба хаагч 2 автомашинтайгаар, БНХАУ-ын ХЗСайд Монгол Улсад айлчлах үеийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хамгаалалт зохицуулалт Хан-уул дүүргийн нутаг Туул гарден хотхоноос баруун тийш Хүннү молл худалдааны төв хүртэл 2017 оны 11 дүгээр сарын 6, 8-ны өдрүүдэд 9 цэгт 10 алба хаагч 2 автомашинтайгаар, Төрийн ордноос Шүүхийн Ерөнхий Зөвлөл орох үед 10 цэгт 10 алба хаагч, Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс “Централ Тауэр” орох үед 10 цэгт 10 алба хаагч, Улсын дээд шүүхээс Хууль зүй дотоод хэргийн яам орох үед 6 цэгт 6 алба хаагч, Хууль зүй дотоод хэргийн яамнаас Занабазарын музей орох үед 10 цэгт 11 алба хаагчийг тус тус удирдан зохион байгуулан ажилласан бөгөөд дээрх хамгаалалтад давхардсан тоогоор 978 алба хаагч 34457 хүн цаг ажилласан.

Гурав. Сахилга хариуцлага, сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх болон авлигаас урьдчилан сэргийлэх ажлын талаар:

а. Алба хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ, түүний үр дүн:

Чингэлтэй дүүрэг дэх замын цагдаагийн хэлтэс нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зам тээврийн осол хэргийг бууруулах чиглэлээр холбогдох хууль, тушаал, шийдвэрүүдийг биелүүлэх, цаг үеийн мэдээ мэдээллийг хэлтсийн бие бүрэлдэхүүнд долоо хоногт 2 удаа хэлтсийн хурлаар алба хаагчдад танилцуулж, долоо хоногийн даваа гаригт хийдэг офицеруудын хурлыг “Сахилгын хурал” болгосноор алба хаагчдын ажлын үр дүн, сахилга хариуцлагын талаар авч хэлэлцэж, сайн ажиллаж байгаа алба хаагчдыг урамшуулах, ажлын алдаа дутагдал гаргасан алба хаагчдыг дахин зөрчил дутагдал гаргуулахгүй байх талаар анхааруулж ажлын үр дүнг тооцон удирдан зохион байгуулан ажиллаж байна. 2017 оны байдлаар Сахилгын хурлыг 38 удаа, сахилгын зөвлөгөөнийг 3 удаа тус тус зохион байгуулж хурлаар хэлтсийн бүх алба хаагчдыг оруулж, тэдний хийж гүйцэтгэсэн ажлын үзүүлэлт, амжилт, алдаа онооны талаар хэлэлцэж, цаашид хэрхэн ажиллах талаар болон өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой 176 төрлийн үүрэг ажлын

чиглэл, зааварчилгаа өгч биелэлтэн дээр нь хяналт тавин ажилласан байна. Сахилга ёс зүйн хурлыг тогтмол зохион байгуулснаар хэлтсийн хэвийн үйл ажиллагаа, захирах захирагдах ёс, хүний эрхийг хангах, алба хаагчийн сахилга, хариуцлагыг журамлан зохицуулснаар алба хаагчид ажил албандаа хандах хандлага нь сайжирч ажлын бүтээмж цаг ашиглалтын менежмент нь нэмэгдэж зохион байгуулалт сайжирхад нөлөөлөх ажил болж байна.

Замын цагдаагийн албаны дарга, цагдаагийн хурандаа Б.Даваазулын 2017 оны 09 дүгэр сарын 28-ны өдрийн 13/3267 дугаартай албан бичгийн дагуу Монгол Улсын Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Цагдаагийн ерөнхий газраас хэрэгжүүлэх арга хэмжээний нэг дэх үе шатны төлөвлөгөө /2017-2019 онд/-г Замын цагдаагийн албаны Захиргаа удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн н.Намжилдорж тус хэлтсийн удирдлагууд 2017 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр гардуулсан. Уг Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Цагдаагийн ерөнхий газраас хэрэгжүүлэх арга хэмжээний нэг дэх үе шатны төлөвлөгөөг алба хаагч нарт танилцуулж, цаашид хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах үүрэг чиглэл өгсөн.

Албаны бэлэн байдлыг шалгах зорилгоор ЗЦА, НЗХХГ болон хэлтсээс зарласан нийт 14 удаагийн түргэн цугларалтад алба хаагчдыг бүрэн хамруулж, нэг бүрийн тусгай хэрэгсэл, агсамж болон дүрэмт хувцасны өнгө үзэмжийг шалгаж зөрчил заагдсан алба хаагчдад хугацаатай үүрэг өгч зөрчлийг бүрэн арилгуулж бэлтгэл ажлыг хангуулсан.

б. Сахилга, ёс зүйн зөрчлийн мэдээ, прокурор, шүүхийн мэдэгдэл, шаардлага:

Алба хаагчдын сахилга, ёс зүй, албаны бэлэн байдлыг сайжруулах чиглэлээр энэ оны эхний 11 сард сахилгын хурлыг нийт 38 удаа, сахилгын зөвлөгөөнийг 3 удаа тус тус зохион байгуулаад байна. Хурлаар дээд шатны байгууллага, алба тушаалтаас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэл, зөвлөмжийг биелэлтийг хангуулах, хэлтсийн албаны үйл ажиллагааг сайжруулах, алба хаагчдаар тодорхой төрлийн ажил, үүрэг гүйцэтгүүлэх, алба хаагчдын өдөр тутмын ажлын үр дүнг сайжруулах ажлын хүрээнд хэлтсийн дарга, ахлах зохицуулагч нараас 2017 оны эхний 11 сарын байдлаар 128 удаагийн үүрэг, ажлын чиглэл, 54 удаагийн зөвлөмж, зааварчилгааг бичгээр болон хэлтсийн хурлын тэмдэглэлээр өгч үр дүнг тухай бүрд нь тооцож ажилласан байна.

Ахлах зохицуулагч, цагдаагийн ахмад Б.Зоригт хэлтсийн алба хаагчдаас гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, өртөж хохирсон талаарх мэдээллийг Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сангаас шүүж дүн мэдээг сар бүрийн 23-ны өдөр Замын цагдаагийн албаны Захиргааны удирдлагын хэлтэс албан тоотоор хүргүүлж хэвшсэн. 2017 оны 07 дугаар сард тус хэлтсийн цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлагч М.Мөнхбаясгалан Үндэсний Их баяр наадмын хурдан морины хамгаалалтын үед бусадтай маргалдсан зөрчил бүртгэгдсэн бөгөөд Одоогоор Авилгалтай тэмцэх газар шалгагдаж байна.

в. Алба хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх чиглэлээр дотооддоо зохион байгуулсан сургалт:

Алба хаагчдад сургалтыг тасралтгүй хүртээмжтэй хэлбэрээр хүргэх үүднээс “Станцаар явуулах сургалтын” хуваарь гаргаж 614 постны суурин станцаар ажлын өдрүүдэд 09:00, 16:00 цагуудад буюу өдөрт 2 удаа Ёс зүй, Замын хөдөлгөөний дүрэм, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам зэрэг 152 удаагийн 79 цаг сургалт оруулсан. Алба хаагчдын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, харилцааны соёлын түвшинг

ахиулах зорилгоор сургалтыг танхимын, станцаар, практик зэрэг 3 төрлөөр сургалтуудыг тус тус зохион байгуулсан. Цагдаагийн байгууллагын удирдах ажилтны 2017 оны сургалт, зөвлөгөөний үед Хууль зүй дотоод хэргийн сайд болон Цагдаагийн ерөнхий газрын дарга нараас өгсөн үүрэг, Замын цагдаагийн албаны дарга, Захиргааны удирдлагын хэлтсийн даргаас өгсөн үүрэг, ажлын чиглэл, зөвлөмжийн дагуу хэлтсээс 2017 онд зохион байгуулах Сургалтын календарчилсан төлөвлөгөө, Эрх зүйн сургалт, сурталчилгааны дэд төлөвлөгөө, Сургалтын чанар үр дүнг дээшлүүлэх чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө зэрэг нийт 8 төлөвлөгөө боловсруулж 2017 оны эхний 11 сарын байдлаар 24 төрлийн 204 удаагийн 111 цагийн сургалт оруулах ажлыг зохион байгуулж биелэлт үр дүнг тооцон ажиллаж байна.Үүнд:

Хэрэг бүртгэгч, зохицуулагч нарт:

- ❖ Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажиллагаа
- ❖ Захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа
- ❖ Зам тээврийн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа
- ❖ Замын хөдөлгөөний дүрэм
- ❖ Тусгай дуут дохиот тээврийн хэрэгслийг жолоодох

Цагдаа зохицуулагч нарт:

- ❖ Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажиллагаа
- ❖ Захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа
- ❖ Зам тээврийн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа

Нийт алба хаагч нарт:

- ❖ Монгол Улсын зөрчлийн тухай хууль
- ❖ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
- ❖ ЦБҮАЖ /код-108/ Цагдаагийн байгууллагын ажлыг төлөвлөх тайлагнах
- ❖ ЦБҮАЖ /код-120/ Архив албан хэрэг хөтлөлт
- ❖ ЦБҮАЖ /код-207/ [Зам тээврийн ослын газрыг хамгаалах, үзлэг хийх журам](#)
- ❖ Биет зохицуулалтын талаар
- ❖ Гадаад хэлний сургалт
- ❖ Сонгуулийн тухай хууль
- ❖ Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль
- ❖ Цагдаагийн албаны тухай хууль
- ❖ Биет зохицуулалтын талаар
- ❖ Ёс зүй харилцаа хандлагын талаар
- ❖ Зөрчлийн тухай хууль
- ❖ Зөрчлийг шалган шийдвэрлэх тухай хууль зэрэг 24 төрлийн тэнхмийн сургалтыг албан тушаалаар төрөлжүүлэн орсон байна.

Хэлтсийн алба хаагчдын замын хөдөлгөөний дүрмийг мэдлэгийг сайжруулах зорилгоор “Номгон Санчир” , “София” жолооны курсийн багш нарыг урьж 6 удаагийн 9 цагийн тэнхмийн сургалтыг зохион байгуулан ажиллаж байна.

г. Төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулагдсан сургалт уулзалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөнд алба хаагчдыг хамруулсан байдал:

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хуулийн ач холбогдол, үзэл баримтлал, мөн чанарыг иргэдэд сурталчилах, ойлгуулах тэднээр хууль биелүүлэх, үүрэг хариуцлагыг ухамсарлуулах, хүлээх хариуцлагын талаар дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан алба хаагч,

ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн багш, оюутан сурагчдад сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулан иргэдэд олон нийтэд мэдээлэн ажилласан. Үүнд:

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 72, 49, 5, 23, 24, 39, 138, 37, 50, 117, 140, 17 дугаар сургууль, 5, 33, 39, 70, 19, 9, 37, 74, 108, 173, 224, 174, 4, 31, 126, 83, 102, 220 дугаар цэцэрлэг, СУИС, Чингэлтэй дүүргийн Гал унтраах 10 дугаар анги, Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл шуурхай удирдлагын төв, Сургалтын нэгдсэн төв зэрэг байгууллагуудад Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, Зөрчлийн тухай хууль, тогтоомж, журмын дагуу давхардсан тоогоор 122 удаагийн 74 цагийн сургалтыг зохион байгуулсан. Мөн 2017 оны эхний 11 сарын байдлаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу Чингэлтэй дүүргийн ТҮК, Эрдэмтранс, Оршил констракшн ххк, Алтжин худалдааны төв, Хүчит шонхор, Нарантуул-2 худалдааны төв, Эрдэнбулган ххк, Улсын их дэлгүүр, Уланбаатар зам засвар арчлалтын компани, Монгол хьондай автоматив зэрэг аж ахуй нэгж байгууллагуудад давхардсан тоогоор 51, дүүргийн 19-н хорооны Засаг дарга нарт болон Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын 15 сургуулиудад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн дагуу давхардсан тоогоор 64, нийт 115 албан мэдэгдэл, шаардлага хүргүүлж, мэдэгдлийн мөрөөр зохион байгуулсан ажлын хариуг фото талаар баримтжуулан авч ажиллаж байна.

Чингэлтэй дүүргийн прокурорын газраас 09 дүгээр сарын 14-ны өдөр хяналтын прокурор Н.Алтантүлхүүр Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, түүнд анхаарах асуудлууд сэдвээр 45 минутын сургалт зохион байгуулсан. Тус сургалтанд хэлтсийн 52 алба хаагч хамрагдсан.

Замын цагдаагийн албанаас 2017 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр Хан-уул дүүргийн нутаг дэвсгэрт Онцгой байдлын гамшгийн сургалтын төвд “газар хөдлөлт, гал түймэр”-с урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулагдсан сургалтанд хэлтсийн бүх алба хаагчид өглөө 08:00, өдөр 16:00 цагаас 2 ээлжээр тус тус хамрагдсан.

Тус хэлтэс шинээр томилогдсон 2 алба хаагчийг 10 дугаар сарын 04-06-ны өдрүүдэд Цагдаагийн ерөнхий газрын сургалтын төвд “Биет зохицуулалт”-ын сургалтанд хамруулсан.

Хэлтсийн алба хаагчид Замын цагдаагийн албан баталсан хуваарийн дагуу Иргэд үйлчлэх төв /Лицензийн төв/-д 2017 оны 10 дугаар сарын 14-ны өдөр Замын хөдөлгөөний дүрмээр шалгалт өгөх ажлыг зохион байгуулсан. Тус шалгалтанд ээлжийн амралттай 4 алба хаагчдаас бусад алба хаагчид бүрэн хамрагдсан.

Улсын Ерөнхий прокурор, Нийслэлийн прокурорын газартай хамтран “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд тулгарч буй хүндрэл бэрхшээл” сэдэвт семинарт 2017 оны 11 –р сарын 02-ны өдөр хэрэг бүртгэгч, цагдаагийн ахмад Г.Өнөрбаатар, цагдаагийн ахлах дэслэгч Т.Заяасайхан, цагдаагийн дэслэгч Л.Нармандах нар оролцсон.

Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах нийт 23 цэцэрлэгийн хүүхдүүдэд хэлтсийн цагдаа зохицуулагч нар “Замын хөдөлгөөний аюулгүй байдал” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд нийт 28-н бүлгийн 1095 орчим сурагч хамрагдсан.

Хөдөлмөрийн дээд сургууль, Соел урлагын дээд сургуулиудад тус тус “Замын хөдөлгөөний соёл” сэдэвт сургалт орсон. Сургалтанд 1-р курсын 5 ангийн нийт 600 гаруй оюутан залуучууд хамрагдсан.

д. Зохион байгуулсан соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээ:

Алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хэлтсийн удирдлагаас алба хаагчдын, ар гэрээр орж, ахуй амьдралтай танилцаж судалгаа гаргах хуваарийн дагуу 2017 оны 01 сарын 04-нөөс 2017 оны 01 сарын 10-ны өдрүүдэд хэлтсийн дарга, ахлах зохицуулагч нар алба хаагчдын ар гэр ахуй амьдралтай нь танилцаж, тэднээс гаргаж байгаа санал хүсэлтийг сонсож 12 төрлийн судалгаа гаргасан мөн гэр бүлийн гишүүдтэй 2017 оны 01 сарын 28-ны өдөр хэлтсийн хурлын зааланд уулзалт зохион байгуулж, тэдний хүсэлтийг сонсож, харилцан ярилцаж цаашид гэр бүлийн уулзалт, Зөрчил дутагдал гаргаж болзошгүй

нэр бүхий 5 цагдаа зохицуулагчийн ар гэрээр зохицуулагч нарыг оруулж тэдний гэр бүлийнхэнтэй уулзаж, ахуй амьдралын талаар 12 төрлийн судалгаа авсан, алба хаагчдын гэр бүлийн гишүүдтэй 2017 оны 01 сарын 28, 09 сарын 08-ны өдрүүдэд хэлтсийн хурлын зааланд 2 удаа уулзалт зохион байгуулж, алба хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн асуудлыг сайжруулах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажил, цаашид хийхээр төлөвлөж байгаа ажлын талаар товч танилцуулж, албаны үйл ажиллагаатай холбоотой санал хүсэлтийг сонсож харилцан ярилцсан. Хэлтсийн алба хаагчдын гэр бүлийн гишүүдийн төлөөлөл болгож хуучин 11 хний бүрэлдэхүүнтэй байсан “Гэр бүлийн гишүүдийн зөвлөл”-ийг 5 хүний бүрэлдэхүүнтэй болгож өөрчилсөн. Хүрэлцэн ирсэн гэр бүлийн гишүүдэд хэлтсийн байрны зохион байгуулалт, өдөр тутмын үйл ажиллагааг танилцуулж, хэлтсийн дарга алба хаагчдын гэр бүлийн хүмүүстэй тусгайлан уулзаж санал хүсэлтийг нь сонсож, тэдний дунд ширээний теннисний тэмцээн зохион байгуулж, гэр бүлийн 36 гишүүнд хэлтсийн удирдлагуудаас дурсгалын зүйл гардуулсан. Залуу гэр бүлийг дэмжих “Аз жаргалын эрэлд” төслийн уралдаан тэмцээнд 1 алба хаагчийг оролцуулан дэмжиж 2 өрөө байраар шагнуулсан. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан хэлтсийн алба хаагчдын ар гэр, үр хүүхдүүдийг 2017 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Тэнгис кино театрт кино үзүүлж, гарын бэлэг өгч, Тусгаар тогтнолын талбай дээр хүүхдүүдийг тоглуулан алба хаагчдын ар гэр, үр хүүхдүүдийн дунд халуун дулаан уур амьсгалыг бүрдүүлэн нэг өдрийг өнгөрүүлсэн. Мөн удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг цаг тухайд нь биелүүлсэн, хийсэн ажлаараа хамт олноо хошуучлан сайн ажилласан алба хаагчдыг гэр бүлийн хамт Маск продакшны хошин шог, Single lady-3 зэрэг 6 удаагийн урлаг соёлын арга хэмжээ үзүүлэх ажлыг зохион байгуулж давхардсан тоогоор 42 алба хаагчийг гэр бүлийн гишүүдийн хамт хамруулаад байна.

Хэлтсийн даргын санаачлагаар чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх үүднээс офицер, цагдаа нарын дунд “Биллярд”-ны тэмцээнийг 2 удаа зохион байгуулсан.

Замын цагдаагийн алба болон хэлтсээс гавъяаны амралтанд гарсан ахмад ажилтан, цагдаагийн бэлтгэл офицер О.Батжаргал, О. Гантөмөр, бэлтгэл ахлах ахлагч Л.Энхбаяр нарыг урьж 3 удаагийн 3 цагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар албаны түүхэн замнал, ажиллаж ирсэн туршлагын талаар ярилцаж албаараа бахархах, албандаа үнэнч, бусдыг хүндэтгэх ухамсрыг төлөвшүүлэх талаар алба хаагчидтай харилцан ярилцсан.

Уламжлалт Сар шинийн баярыг тохиолдуулан тус хэлтсийн ахмад ажилтнуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэн Их тайга компаний гарын бэлэг өгөх ажлыг зохион байгуулсан. Мөн 10 ахмад ажилтанг ахмадын амралтын газар сувилалд амраасан. Ахмадын баярын өдрийн тохиолдуулан ахмад ажилтангуудын хүлээн авч гарын бэлэг гардуулсан.

Зохицуулагч, цагдаагийн ахмад Б.Амарсанааг Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газрын зардлаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсад Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлийн 14 хоногийн сургалтад 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс, ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч Ц.Чинзориг өөрийн зардлаар Япон улсад туршлага судлах үүднээс 2017 оны 06 дугаар сарын 08-ны өдрөөс 5 хоног тус тус томилолтоор ажилласан.

Янзага хүүхдийн зусланд хэлтсийн 3 алба хаагчийн тус бүр 1 хүүхдийг 7 хоногийн хугацаатайгаар үнэ төлбөргүй амраасан. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах үүднээс Замын цагдаагийн албанаас зохион байгуулсан 1 алба хаагчид 1 тонн нүүрсийг 50,000 төгрөгөөр олгуулах арга хэмжээнд гэр хороололд оршин суудаг 12 алба хаагчийг хамруулсан.

Зам тээврийн эзэнгүй хүн амины гэмт хэргийг мэргэжлийн өндөр ур чадвар гаргаж илрүүлсэн зохицуулагч, цагдаагийн дэслэгч Л.Тэгшжаргал, цагдаа зохицуулагч, ахлагч О.Баярхүү, дэд ахлагч А.Эрдэнэдаваа нарыг шагнуулахаар Замын цагдаагийн албаны 2017 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн зөвлөлийн хурлаар оруулж 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр д/ч Л.Тэгшжаргал ЦЕГ-ын “Хүндэт Жуух”-аар, а/ч О.Баярхүү, д/а А.Эрдэнэдаваа нар ЦЕГ-ын “Баярын бичиг”-ээр тус тус шагнагдсан.

Хэрэг бүртгэгч нар байцаалт, мэдүүлгийн өрөөтэй болгох ажлын хүрээнд өрөөний хэмжээ 8м² хэтрэхгүй байх, агааржуулагчтай байх, дулаан хэмжигчтэй байх зэрэг шаардлагуудыг хангаж, хэрэг бүртгэлтийн өрөө, болон бүсийн өрөөг стандартын дагуу тохижуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Чингэлтэй дүүргийн аварга шалгаруулах олон төрөлт тэмцээн төрийн байгууллагын алба хаагчдын дунд зохион байгуулагдаж 2017 оны 10 дугаар сарын 05-ны өдөр “Олс таталт”, “Дартс”, “Ширээний теннис”, “Таваг шидэлт”-ийн тэмцээнүүдэд хэлтсийн алба хаагчид амжилттай оролцсон.

“Уран зохицуулагч” ажил мэргэжлийн аварга шалгаруулах 2017 оны тэмцээнд Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан зохицуулагч, цагдаагийн ахлах дэслэгч Ч.Чимэдбат, цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч Д.Ганболд, дэд ахлагч Б.Отгонбаяр нар оролцож тэргүүн байр эзэлсэн.

е. Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажилласан байдал:

Монгол улсын Ерөнхийлөгчийн “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж байх тухай 2007 оны 190 дүгээр зарлиг, “Засгийн газрын журам батлах тухай” 2007 оны 190 дүгээр тогтоолын дагуу төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, үйл ажиллагаагаа сурталчлах, иргэдийн санал бодлыг сонсох зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Сүхбаатарын талбайд зохион байгуулсан “Иргэдэд ойр, эрх зүйн үйлчилгээ” нээлттэй хаалганы өдөрлөг, Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газрын даргын 2017 оны 05 дугаар сарын 22-ны А/165 дугаар тушаалаар “Бид сайн сайханд дагуулна” уриатай иргэдийн баярын арга хэмжээ, Замын цагдаагийн албанаас зохион байгуулсан “Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх өдөр” арга хэмжээ, “Хүүхдийн хүчирхийллийн эсрэг хамтдаа 2017” аяны хүрээнд Чингэлтэй дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын 19-н сургуультай хамтран “Хүүхдийн эрхийг дээдэлж гэр бүлийн хүчирхийллийг зогсооцгооё” өдөрлөг зэрэг 9 төрлийн арга хэмжээнд оролцож зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 20 төрлийн 1450 ширхэг тараах материал, гарын авлага тарааж, албаны үйл, ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг иргэдэд хүргэж ажилласан Өдөрлөгт 1780 иргэд, 19-н сургуулийн 4750 хүүхэд хамрагдсан.Бага насны хүүдэд замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, замын хөдөлгөөнд оролцох дадал эзэмшүүлэх, эцэг эх асран хамгаалагч, боловсролын байгууллагын ажилтнуудын үүрэг оролцоог нэмэгдүүлэх , зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, шинээр батлагдсан хууль, тогтоомж, тушаалын шийдвэр зэрэг 9 төрлийн давхардсан тоогоор 125 удаагийн 156 цагийн сургалтыг зохион байгуулсан байна.

“Австралид суралцагчид” олон улсын байгууллагатай хамтарч Чингэлтэй дүүргийн 5 дугаар сургуулийн гадна орчинг “Сургуулийн орчмын бүс” стандартын дагуу тохижуулсан.

Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэр Баянбүрдийн аюулгүй тойрог / 614-р пост/-ноос Гэсэр сүмийн уулзвар /608-р пост/ орох замд 01 сарын 18-ны өдөр Eagle телевизтэй хамтран Чингэлтэй дүүргийн замын цагдаагийн хэлтсийн үйл ажиллагааг таниулах зорилгоор Хүрэмт 11,12,13 дугаар бүсийн автомашинуудыг Drone-оор бичлэг хийж эфирээр цацаж иргэд олон нийтэд сурталчилж ажилласан.

Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлд Зуслангийн замдхурдны мэдээлэх электрон самбар 2 ширхэгийгбайрлуулах саналыг хүргүүлснээр 800.000 төгрөгний хөрөнгийг шийдвэрлүүлж 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс Чингэлтэй дүүрэг 19-р хороо 117-р сургуулийн баруун замд байрлуулан зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажилд ашиглаж байна. Чингэлтэй дүүргийн нутаг 19-р хороо Зуслангийн замд 2017 он гарсаар Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн гаралт нэмэгдсэнтэй холбоотой тус дүүргийн Замын цагдаагийн хэлтсээс зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөөврийн “Хурд хэмжигч” байрлуулан хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслүүдэд хяналт тавьж, хурд хэтрүүлэх болон

согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож байгаа зөрчлүүд дээр хэсэгчилсэн арга хэмжээг хөдөлгөөнт байдлаар зохион байгуулсан. МҮОНРТ-д Зөрчлийн тухай хууль болон согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчилд хүлээлгэх хариуцлагын талаар хэрэг бүртгэгч, цагдаагийн ахлах дэслэгч Т.Заяасайхан 2017 оны 08 дугаар сарын 01-ний өдөр, Тус хэлтэс нь 2017 оны 09 дүгээр сарын 14-ны өдөр Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Нийслэлийн боловсролын газар, Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс, албан журмын даатгалын холбоо, Хүүхэлдэйн театр, С1, MN25, SBN, Royal HD телевизүүдтэй хамтран “Үлгэрийн баатрууд”-аар замын хөдөлгөөнд оролцож байгаа жолооч нарын сахилга, соёлыг дээшлүүлэх зорилгоор явган хүний гарц болон сургууль орчмын бүсэд анхаарал болгоомжтой оролцох, хурдаа хасах, зам тавьж өгөхийг жолооч нарт уриалж, бие даан замын хөдөлгөөнд оролцож байгаа бага насны хүүхдүүдэд анхаарал болгоомжтой оролцох талаар тайлбарлаж, тэднийг гарахад туслах ажлыг зохион байгуулсан.

Хүүхдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2017 оны 09 дүгээр сарын 14-ны өдөр Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Нийслэлийн боловсролын газар, Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс, албан журмын даатгалын холбоо, Хүүхэлдэйн театр, С1, MN25, SBN, Royal HD телевизүүдтэй хамтран Ерөнхий боловсролын 17, 120 дугаар сургуулийн бага ангийн сурагчдад “Үлгэрийн баатрууд”-аар дамжуулан замын хөдөлгөөнд хэрхэн яаж зөв соёлтой оролцох талаар хөгжөөнт байдлаар асуулт хариултын тэмцээн зохион байгуулсан. Тус сургалтанд 3100 гаруй сурагч, эцэг, эх, асран хамгаалагч, багш ажилчид хамрагдсан. Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан зохицуулагч, цагдаагийн ахлах дэслэгч Ч.Чимэдбат 2017 оны 09-р сарын 07-ны өдөр ФМ 100,9 радиогийн шууд эфирээр “ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ СОЁЛ” сэдэвтэй 1 цаг 30 минутын хугацаатай нэвтрүүлэгт оролцож цагдаагийн ерөнхий газар, Замын цагдаагийн албанаас гэмт хэрэг ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж байгаа ажил, цаашид зохион байгуулах, хэрэгжүүлэх ажлын талаар, Royal телевизийн 50 минутын хугацаатай “Иргэний боловсролд” нэвтрүүлэгт оролцож үзэгчидтэй шууд утсаар холбогдож тэдний асуусан асуултанд хариулт өгч мөн хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлж байгаа ажил болон цаашид хийж хэрэгжүүлэх ажлын талаар тус тус иргэд олон нийтэд мэдээ мэдээлэл хүргэсэн.

Тайлангийн хугацаанд зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хуулийн ач холбогдол, үзэл баримтлал, мөн чанарыг иргэдэд сурталчилах, ойлгуулах тэднээр хууль биелүүлэх, үүрэг хариуцлагыг ухамсарлуулах, хүлээх хариуцлагын талаар болон Замын цагдаагийн албанаас хэрэгжүүлж байгаа ажил, цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа ажлуудын талаар давхардсан тоогоор нийт Монголын үндэсний радио телевиз, Монгол HD TV, Eagle TV, С1 TV, MN-25 TV, TV8 TV, Royal TV, MNC TV, UBS TV гэх мэт давхардсан тоогоор 69 телевизэд тус бүр 3-10 минутын мэдээ, мэдээлэл өгч ажилласан. Мөн Авторадио 96,3-д замын цагдаа таныг сонсож байна шууд эфирт хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Сүхбат, ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч Ц.Чинзориг, замын зохион байгуулалт хариуцсан зохицуулагч, цагдаагийн ахмад Б.Амарсанаа, урьдчилан сэргийлэх ажил хариуцсан зохицуулагч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Зориггоо, дэслэгч Ч.Чимэдбат нар Замын цагдаагийн албанаас зохион явуулж байгаа нэгэдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний талаар болон замын нөхцөл байдлын талаар, ЗХД-ийн 15 дугаар зүйлд заасан “Гадна талын гэрэлтүүлэг хэрэгсэл хэрэглэх” зэрэг бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу 28 удаагийн санамж сэрэмжлүүлэг иргэд жолооч нарт хүргүүлж ажилласан.

**ё. Техник, замын хяналтын чиглэлээр хийж
гүйцэтгэсэн ажил, арга хэмжээ:**

Дүүргийн нутаг дэвсгэрт замын хөдөлгөөнийг оновчтой зөв зохион байгуулах, хөдөлгөөний түгжрэл саатлыг бууруулах, жолооч, явган зорчигч нарт замын хөдөлгөөнд зөв соёлтой оролцох, зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, мэдээ, мэдээлэл өгөх зорилгоор шаардлагтай тэмдэг, тэмдэглэлийн захиалгыг Нийслэлийн засаг даргын тамгын газар, Дүүргийн засаг даргын тамгын газар, Замын цагдаагийн албаны Техник, замын хяналтын хэлтэс, Нийслэлийн автозамын хөгжлийн газар, Улаанбаатар зам засвар, арчлалтын газарт тус тус хүргүүлж ажилласан. **Үүнд:**

Нийслэлийн засаг даргын тамгын газартай хамтарч Дүүргийн 19 дүгээр хороо “Яргайтын богино” зуслангийн асфальтан хучилттай 2,5 км, 12 дугаар хороо Гахайн байрнаас хойшоо Хайлаастыг холбосон 1,6 км асфальтан хучилттай болон ЭКО чулуун хучилттай 1,5 км, Дүүргийн засаг даргын тамгын газартай хамтарч 7, 9,10,11,16,17,18,19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 8,7 км буюу нийт 14,3 км автозамыг шинээр ашиглалтад оруулсан.

Хайс хашлаганы талаар: Шаардлагатай гудамж замуудад явган зорчигчийг гарцгүй хэсгээр зам хөндлөн гарахаас урьдчилан сэргийлж, зорчих хэсгийн голоор хайс байрлуулах саналыг Нийслэлийн автозамын хөгжлийн газар, Улаанбаатар зам засвар, арчлалтын газарт хүргүүлснээр:

Чингэлтэй дүүргийн 6 хороо Их тойруу, Баянбүрийн аюулгүйн тойргийн зүүн замд 100 метр, 1 дүгээр хороо Хэрэг бүртгэх албаны урд замд 200 метр, 2 дугаар хороо их тойруу, “Бөмбөгөр” худалдааны төвийн баруун замд 30 метр, 5 дугаар хороо Самбуугийн гудамжинд 60 метр, Хувьсгалын замд 50 метр, Галданбошигтын гудамж, 39 дүгээр сургуулийн зүүн замд 30 метр нийт 470 метр хайсыг зорчих хэсгийн голоор байрлуулсан.

Тэмдгийн талаар: Их иойруу, Баянбүрдэн тойргийн хойд замд 2.1 “Орох хориотой” тэмдэг-1, нэмэлт тэмдэг-1, 4.16 “Баруун гар тийш эргэнэ” тэмдэг-1, Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн зүүн замд 5.16 а,б явган хүний гарц тэмдэг 2, Чингэлтэй дүүргийн 4 хорооны нутаг Бага тойруугийн замд 2.1 “Орох хориотой” тэмдэг 1 ширхэг, 2.27 “Түр зогсох хориотой” тэмдэг 1 ширхэг, 3.4 “Зам тавьж өг” тэмдэг 4 ширхэг, 4.16 “Баруун гар тийш явна” тэмдэг 6 ширхэг, 5.16 а,б “Явган хүний гарц” тэмдэг 2, 5.30 “Хороолол” тэмдэг 9, 5.31 “Хорооллын төгсгөл” тэмдэг 9, 5.32 “Чиглэлийн тээврийн хэрэгслийн буудал” тэмдэг 2 ширхэг гэх мэт тэмдэг шинээр байрлуулах саналыг Нийслэлийн автозамын хөгжлийн газарт хүргүүлж нийт 475 ширхэг тэмдэг шинээр болон нөхөж байрлуулсан.

Тэмдэглэлийн талаар: Нийслэлийн засаг даргын тамгын газартай хамтарч Энхтайваны өргөн чөлөө, Бага тойруу, Самбуугийн гудамж, Их тойруу, Галданбошигтын гудамж, Хайлаастын зам, Энэбишийн өргөн чөлөө, Хувьсгалын замуудын эгнээ хязгаарлах хэвтээ тэмдэглэлийг будаж тодруулсан.

Халтиргаа гулгааны талаар: Дүүргийн тохижилт үйлчилгээний кампани, Хот тохижилтын газартай хамтарч дүүргийн нутаг дэвсгэрт зам, замын зорчих хэсэгт халтиргаа гулгаа үүссэн хэсэгт 450 тонн давс, бодис цацуулж зам тээврийн хэрэг, осол гархаас урьдчилан сэргийлж ажилласан.

Шинээр санаачилсан ажил: Түгжрэлийг бууруулах ажлын хэсгийн ахлагч н.Баярхүү, Чингэлтэй дүүргийн засаг дарга Ж.Эрдэнбат, Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын газрын дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Эрдэнэбат нарт Бөмбөгөр худалдааны төвийн урд талын замыг шинээр зохион байгуулах саналыг танилцуулсан. Чингэлтэй дүүргийн 2 дугаар хороо Урт цагааны урд талын 2 зогсоолын Чингэлтэй дүүргийн 2 дугаар хороо Урт цагааны урд талын 2 зогсоолын талбай эвдэрч муудсан байсныг засаж сайжруулах саналыг Чингэлтэй дүүргийн Засаг даргад танилцуулж хөрөнгийг шийдвэрлүүлж зогсоолын талбайг эко чулуун хавтангаар шинэчилсэн. Замын хөдөлгөөний түгжрэл саатлыг бууруулах чиглэлээр “Бөмбөгөр” худалдааны төвийн ойр орчмын хөдөлгөөн зохион байгуулах 19 саналыг дрон ашиглан гаргаж танилцуулгыг Техник замын хяналтын хэлтсийн даргад хүргүүлснээр Гэсэр сүмийн зүүн талаар хойшоо Залуучуудын өргөн чөлөөг холбосон 300 метр асфальтан хучилттай замыг ашиглалтад оруулаад байна.

**ж. Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан
ажил, арга хэмжээний талаар, түүний үр дүн:**

2017 оны 01 сард хэлтсээс 25 офицер 2016 оны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэгийг бөглөж баталгааны хуудсанд алба хаагчаар гарын үсэг зуруулан албажуулан тоотын хамтаар Замын цагдаагийн албаны Нийслэлийн Замын хөдөлгөөний хяналтын газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст хүргүүлсэн.

Замын цагдаагийн албаны даргад Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс 2017 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн №04 тоот ирүүлсэн мөрдөн байцаагчийн мэдэгдлийг нийт алба хаагчдад танилцуулж, алба хаагчдыг авлигаас ангид байх талаар 5 төрлийн заалт бүхий баталгааг алба хаагчдад танилцуулан гарын үсэг зуруулан баталгаажуулж авсан.Тус хэлтэс нь 2017 оны эхний 11 сарын байдлаар алба хаагчдаас авилга, хээль хахуул өгч авахгүй байхгүй талаар нийт 87 удаагийн баталгааг авсан байна.

Ахлах зохицуулагч цагдаагийн ахмад Б.Зоригт Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль болон бусад хууль тогтоомжийн талаар 2 удаа 2 цагийн сургалт орсон.

Хэлтсийн байрны хүлээлгийн танхимд байрлах лед дэлгэцээр “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг сурталчлах” ажлын хүрээнд Авлигалын эсрэг хуулийн танилцуулгыг бэлтгэж хэлтсээр үйлчлүүлж байгаа иргэд жолооч нарт хүргэж байна.

Алба хаагчдад сургалтыг тасралтгүй хүртээмжтэй хэлбэрээр хүргэх үүднээс “Станцаар явуулах сургалтын” хуваарь гаргаж 614 постны суурин станцаар ажлын өдрүүдэд 09:00, 16:00 цагуудад буюу өдөрт 2 удаа Ёс зүй, Харилцаа хандлагын, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам зэрэг 152 удаагийн 79 цаг сургалт оруулсан бөгөөд 2017 онд хэлтсийн алба хаагчдаас авлига, ашиг сонирхлын зөрчилд холбогдсон тохиолдсон гараагүй байна.

**Дөрөв. Алба хаагч, ажилтны ажиллах нөхцөл байдал
нийгмийн асуудлыг дээшлүүлэх чиглэлээр:**

**а. Алба хаагчдын ажиллах нөхцөл байдал,
нийгмийн асуудлыг дээшлүүлэх чиглэлээр:**

Чингэлтэй дүүргийн Засаг даргатай 2017 онд байгуулсан үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажил үйлчилгээнээс зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хурд хэмжигч, мотоцикль, нөүтбүүк, ширээ сандал, гадна талын тамбар, суурин станц ус цэвэршүүлэгч, гэрэл зургийн аппарат 12ш, телевиз зэрэг 19 төрлийн тоног төхөөрөмжийг авах асуудлыг шийдвэрлүүлж, дүүргээс худалдан авах тендрийн ажиллагааг зохион байгуулж, тендерт “Гольден прогресс”ХХК-иас компьютер-5, принтер-3, notebook-1, чанга яригч-2, ширээ-2, шкаф-2, сандал-12, хөшиг-5, мотоцикль-2, ус цэвэршүүлэгч-2 ширхэг, зургийн аппарат-12, хурд хэмжигч төхөөрөмж зэрэг нийт 40 сая төгрөгний эд зүйлсийг авч алба хаагчдад хуваарилан өгч албаны үйл ажиллагаанд ашиглаж байна.

Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газраас 9,8 сая төгрөгний хөрөнгийг шийдвэрлүүлж Барилга байгууламжийн аюулгүй байдал, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах үүднээс хэлтсийн байрны гадна талд 2017 оны 07 дугаар сард 2*4 хэмжээтэй өргөтгөлийг шинээр барьсан.

Алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хэлтсийн удирдлагаас алба хаагчдын, ар гэрээр орж, ахуй амьдралтай танилцаж судалгаа гаргах хуваарийн дагуу

2017 оны 01 сарын 04-нөөс 2017 оны 01 сарын 10-ны өдрүүдэд хэлтсийн дарга, ахлах зохицуулагч нар хэрэг бүртгэгч, зохицуулагч нарын, ахлах зохицуулагч нар цагдаа зохицуулагч нарын ар гэр ахуй амьдралтай нь танилцаж, тэднээс гаргаж байгаа санал хүсэлтийг сонсож 12 төрлийн судалгаа гаргасан мөн гэр бүлийн гишүүдтэй 2017 оны 01 сарын 28-ны өдөр хэлтсийн хурлын зааланд уулзалт зохион байгуулж, тэдний хүсэлтийг сонсож, харилцан ярилцаж цаашид гэр бүлийн уулзалт, Зөрчил дутагдал гаргаж болзошгүй нэр бүхий 5 цагдаа зохицуулагчийн ар гэрээр зохицуулагч нарыг оруулж тэдний гэр бүлийнхэнтэй уулзаж, ахуй амьдралын талаар 12 төрлийн судалгаа авсан, алба хаагчдын гэр бүлийн гишүүдтэй 2017 оны 01 сарын 28, 09 сарын 08-ны өдрүүдэд хэлтсийн хурлын зааланд 2 удаа уулзалт зохион байгуулж, алба хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн асуудлыг сайжруулах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажил, цаашид хийхээр төлөвлөж байгаа ажлын талаар товч танилцуулж, албаны үйл ажиллагаатай холбоотой санал хүсэлтийг сонсож харилцан ярилцсан. Хэлтсийн алба хаагчдын гэр бүлийн гишүүдийн төлөөлөл болгож хуучин 11 хний бүрэлдэхүүнтэй байсан “Гэр бүлийн гишүүдийн зөвлөл”-ийг 5 хүний бүрэлдэхүүнтэй болгож өөрчилсөн. Хүрэлцэн ирсэн гэр бүлийн гишүүдэд хэлтсийн байрны зохион байгуулалт, өдөр тутмын үйл ажиллагааг танилцуулж, хэлтсийн дарга алба хаагчдын гэр бүлийн хүмүүстэй тусгайлан уулзаж санал хүсэлтийг нь сонсож, тэдний дунд ширээний теннисний тэмцээн зохион байгуулж, гэр бүлийн 36 гишүүнд хэлтсийн удирдлагуудаас дурсгалын зүйл гардуулсан. Алба хаагчдын ар гэрийн гишүүдээс гаргасан санал хүсэлтийг нэгтгэж Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын газрын даргад 2 удаа танилцуулж, гаргасан санал хүсэлтийн дагуу доорх ажлыг зохион байгуулсан. Үүнд:

Залуу гэр бүлийг дэмжих “Аз жаргалын эрэлд” төслийн уралдаан тэмцээнд 1 алба хаагчийг оролцуулан дэмжиж 2 өрөө байраар шагнуулсан, шаардлага нөхцөлийг хангасан 1 алба хаагчийг 8 хувийн зээл хамруулсан, зохицуулагч, цагдаагийн ахлах дэслэгч Д.Шавигцэрэн, цагдаа зохицуулагч, цагдаагийн дэд ахлагч О.Баярхүү нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор Чингэлтэй дүүргийн 16 дугаар хорооны нутагт 0,7 га 2 айлын газар олгож өгөх хүсэлтийг ЗДТГ-т уламжлан газар олгуулсан.

Нэр бүхий 32 алба хаагчид Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны нутагт 0,7 га газрыг өмчлүүлэхээр шийдвэрлүүлж холбогдох байгууллага албан тушаалтнаар газрын өмчлөх гэрчилгээг гаргуулах ажлыг зохион байгуулж байна. Чингэлтэй дүүргийн 17 дугаар хороонд алба хаагчдад авсан 32 айлын газарт цахилгаан, зам, тавиулах, гүний худаг ухуулах, нэгдсэн байдлаар блокон хашаа барих зэрэг асуудлыг шийдвэрлэж өгөх хүсэлтийг дүүргийн Засаг даргад хүргүүлснээр эхний ээлжинд гүний худаг гаргах ажлыг 100 хувь дүүргийн хөрөнгөөр шийдвэрлэхээр болж гүний худгийн кадастрын зураг авах ажлыг эхлүүлээд байна.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан хэлтсийн алба хаагчдын ар гэр, үр хүүхдүүдийг 2017 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Тэнгис кино театрт кино үзүүлж, гарын бэлэг өгч, Тусгаар тогтнолын талбай дээр хүүхдүүдийг тоглуулан алба хаагчдын ар гэр, үр хүүхдүүдийн дунд халуун дулаан уур амьсгалыг бүрдүүлэн нэг өдрийг өнгөрүүлсэн. Мөн удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг цаг тухайд нь биелүүлсэн, хийсэн ажлаараа хамт олноо хошуучлан сайн ажилласан алба хаагчдыг гэр бүлийн хамт Маск продакшны хошин шог, Single lady-3 зэрэг 6 удаагийн урлаг соёлын арга хэмжээ үзүүлэх ажлыг зохион байгуулж давхардсан тоогоор 42 алба хаагчийг гэр бүлийн гишүүдийн хамт хамруулаад байна.

Цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч Э.Өнөрбаярын байшин барих ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор Хөдөлмөрийн сайдад хүсэлт тавьснаар цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч Э.Өнөрбаярт 3,900,000 төгрөгний дэмжлэг үзүүлэх асуудлыг шийдвэрлүүлснээр 2017 оны 01-р сарын 12-нд нүүж орсон.

Нийслэл, дүүргийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх, зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд үр дүн гарган ажилласан алба хаагчдыг ажлыг үнэлүүлэх саналыг дүүргийн засаг даргад хүсэлт

гарган хамтран ажилласнаар зохицуулагч, цагдаагийн дэслэгч Д.Шавигцэрэн 2016 онд Чингэлтэй дүүргийн “Хөдөлмөрийн аварга”, өргөмжлөл 1,000,000 төгрөгөөр, цагдаа зохицуулагч, цагдаагийн дэд ахлагч О.Баярхүүг Чингэлтэй дүүргийн “Хөдөлмөрийн алдар” тэмдгээр тус тус шагнуулсан.

Зохицуулагч, цагдаагийн ахмад Б.Амарсанааг Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газрын зардлаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсад Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлийн 14 хоногийн сургалтад 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс, тасгийн дарга, цагдаагийн хошууч Ц.Чинзориг өөрийн зардлаар Япон улсад туршлага судлах үүднээс 2017 оны 06 дугаар сарын 08-ны өдрөөс 5 хоног тус тус томилолтоор ажилласан.

Чингэлтэй дүүрэг үүсэн байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан дүүргийн Засаг даргын тамгын газраас “Чингэлтэй дүүргийн 25 жилийн ойн медал”-иар 2017 оны 07 дугаар сарын 04-ны өдөр хэлтсийн 53 алба хаагчийг шагнуулсан.

Янзага хүүхдийн алба хаагчдын 3 хүүхдийг 7 хоногийн хугацаатайгаар үнэ төлбөргүй амраах ажлыг зохион байгуулсан.

Хэлтсийн байрыг цэцэгжүүлэх үүднээс 10 төрлийн 25 ширхэг цэцэг худалдан авч, алба хаагчдын өрөө болон хэлтсийн байрны 1, 2 давхарт байрлуулсан.

Мөн хэрэг бүртгэгч нар байцаалт, мэдүүлгийн өрөөтэй болгох ажлын хүрээнд өрөөний хэмжээ 8м² хэтрэхгүй байх, агааржуулагчтай байх, дулаан хэмжигчтэй байх зэрэг шаардлагуудыг хангаж, хэрэг бүртгэлтийн өрөө, болон бүсийн өрөөг стандартын дагуу тохижуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Замын цагдаагийн албанаас алба хаагчдын амьдралд дэмжлэг үзүүлэх зорилгоор Төв аймгийн Батсүмбэр сумын Үдлэг 4 дүгээр багт 7 га газарт төмс тариалах ажлыг зохион байгуулж, төмс хураах ажлыг 09 дүгээр сарын 27-ноос 10 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл зохион байгуулж, алба хаагчдад 1 шуудай төмс, хүнсний ногоо өгөх ажлыг зохион байгуулсан.

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах үүднээс Замын цагдаагийн албанаас 1 тн нүүрсийг 50,000 төгрөгөөр авах хүсэлтэй алба хаагчдын нэрсийг албанд хүргүүлж 10 алба хаагч нүүрс авсан.

б. Эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

Замын цагдаагийн албанаас Төрийн тусгай алба хаагчдын нэгдсэн эмнэлэгтэй хамтран зохион байгуулж байгаа алба хаагчдыг нэгдсэн журмаар эмнэлгийн үзлэгт хамруулах ажлын хүрээнд тус хэлтсийн нийт 48 алба хаагчид шинжилгээ хийлгэж эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулсан. Замын цагдаагийн албанаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Чадварлаг хамт олон 2017” цогцолбор тэмцээнд хэлтсийн алба хаагчдыг бүрэн хамруулж Тус хэлтэс “Мөнгөн Улаанбаатар” цасны баярын үеэр явагдсан хэлтэс хоорондын тэмцээнд тус хэлтсийн баг тамирчид Буухиа тэмцээнд 4-р байр Морьдон барилдаан тэмцээнд 4-р байр Хөлбөмбөгийн тэмцээнд 2-р байр, “Караоке” дууны төрөлд 5-р байр, “Тогооч” төрөлд 4-р байрыг тус тус эзэлсэн.

Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан урлагын үзлэгт 4 алба хаагчийг страд дуу, зохиолын дуу, язгуур урлаг гэсэн 3 төрлөөр оруулж 4 дүгээр байр эзэлсэн. Мөн цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч Н.Одхүү ЦЕГ-ын “Хүч спорт хороо”-ны 2017 оны боксийн аварга шалгаруулах тэмцээний 3 дугаар байр хүрэл меаль, цагдаа зохицуулагч, цагдаагийн дэд ахлагч Э.Анхбаяр ЦЕГ-ын “Хүч спорт хороо”-ны 2017 оны Самбо бөхийн аварга шалгаруулах тэмцээнд 3 дугаар байр хүрэл медаль, Жүдогийн аварга шалгаруулах тэмцээнд 3 дугаар байр хүрэл медаль авсан амжилтыг тус тус үзүүлээд байна. ЦЕГ-ын 2017 оны “Марш тактик”-ын тэмцээнд ЗЦА-ны багт хэлтсээс 3 алба хаагчийн чөлөөлөн оролцуулсан.

Алба хаагчдын бие бялдарыг хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор алба хаагчдыг хөгжүүлэх өрөөнд штанг, теннисний ширээ байрлуулснаар алба хаагчид ажлын бус цагаар өөрийгөө хөгжүүлэх, спортоор хичээллэх, долоо хоногийн Пүрэв гарагт “Хоршоолол” спорт зааланд 21:00 цагаас 23:00 цагийн хооронд сагсан бөмбөг, гар бөмбөг тоглох, Бямба гарагт цагийн амралттай байгаа алба хаагчдыг хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Сүхбат, зохицуулагч, цагдаагийн ахмад У.Батбаяр нар хариуцан Богд ууланд явган аялалыг 3 удаа тус тус зохион байгуулсан. Мөн гудамж замд хяналтын постонд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдад хүчил төрөгчийн коктейль уулгах ажлыг ахлах зохицуулагч, цагдаагийн ахмад Б.Зоригт зохион байгуулан ажиллаж байна.

Алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олны дунд найрсаг уур амьсгал бий болгох үүднээс “Биллъярд”-ны тэмцээнийг офицеруудын дунд 2017 оны 07 дугаар сарын 5-нд, цагдаа нарын дунд 2017 оны 07 дугаар сарын 03-ны өдөр тус тус зохион байгуулсан.

Замын цагдаагийн албанаас 09 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулсан Элэгний В,С вирус шинжилгээнд хэлтсээс 45-аас дээш насны 4 алба хаагчийг хамруулсан.

Замын цагдаагийн албанаас зохион байгуулж буй Чадварлаг хамт олон 2017 цогцолбор тэмцээний “Яг түүн шиг” шоу тэмцээнд 2017 оны 10 дугаар сарын 17-ны өдөр цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч Б.Амарбаясгалан оролцож 8 дугаар байр эзэлсэн.

в. Байгууллагын аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

Чингэлтэй дүүрэг дэх замын цагдаагийн хэлтсийн “Байгууллагын дотоод аюулгүй байлыг хангах орон тооны бус ажлын хэсэгт” хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Сүхбат, ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч Ц.Чинзориг, цагдаагийн ахмад Б.Зоригт, зохицуулагч, цагдаагийн ахмад Б.Алтандөш, Б.Амарсанаа, цагдаагийн ахлах дэслэгч Ч.Чимэдбат, цагдаагийн дэслэгч Л.Тэгшжаргал, цагдаагийн дэд ахлагч П.Билгүүн нарыг томилон ажиллаж байна.

Ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч Ц.Чинзориг 2017 оны 5 дугаар сард “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам” /код-137/-ын дагуу хэлтсийн дотоод аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдлийн үнэлгээг гаргаж, эрсдлийн үнэлгээнд суурилсан төлөвлөгөөг боловсруулсан.

Байгууллагын аюулгүй байдлыг хангах орон тооны бус ажлын хэсгийн гишүүдэд аюулгүй байдлын талаар мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч Ц.Чинзориг ЦБҮАЖ /код 113/ байгууллагын барилга, байгууламжийг гадны гэмт халдлага болон гэнэтийн аюул, осол /байгалийн аюултай үзэгдэл/, алба хаагчдын болгоомжгүй байдлаас үүсэж бий болох хор уршгаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар сургалтын материал бэлдэж 2 удаа 2 цагийн, мэдээллийн аюулгүй байдал, галын аюулгүй байдлын талаар 2 удаа 2 цагийн сургалтыг тус тус зохион байгуулсан байна. Мөн хэлтсээс 2016 онд дотоод аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан ажлын танилцуулгыг Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдал, Төрийн нууц, Шифр харилцааны хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа н.Даваасүрэнд 2017 оны 04 дүгээр сард хүргүүлсэн.

Тус хэлтэс, Чингэлтэй дүүргийн онцгой байдлын хэлтэстэй хамтран 2017 оны 1-р улиралд Учирч болзошгүй гамшиг аюулын үед байгууллагын эд хөрөнгө, баримт сэлтийг хамгаалах, нүүлгэн шилжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө, схем зураг боловсруулж Чингэлтэй дүүргийн Засаг даргаар батлуулан, 2017 оны 03 сарын 23-ны өдөр Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор баталсан гамшигын аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах нэгдсэн дадлага, сургуулилт Улсын хэмжээнд 2017 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 16:00 цагт гамшигын аюулын тухай зарлан мэдээллийн **эхний дуут дохио дугарах үед** Хэлтсийн байранд үүрэг гүйцэтгэж

байсан алба хаагчид Газар хөдлөлтийн үеийн аюулгүй ажиллагааны / **Нуугд-Суу-Хүлээ**/ зарчмыг баримтлан өрөө тасалгаандаа аюул багатай байрлалд өөрийгөө хамгаалах арга хэмжээ авч, ширээн доогуур орох, даацын хана, булан тохой дагуу зогсох дадлага сургуулилт хийсэн. **Хоёр дахь дуут дохио дугарахад** барилга объектыг орхин гарахдаа гараараа болон гарын доорхи зүйлс ашиглан толгойгоо хамгаалан /Гүйхгүй, Эргэж буцахгүй, Хашгирахгүй, Түлхэлцэхгүй/ гэсэн зарчмаар барилгын аюулгүй гарцаар гарч аюулгүй зай талбайд цугларах зэрэг дадлага сургуулилт хийж ажиллаа. Гамшгийн аюулын тухай дохио дугарахад хэлтсийн байранд байсан 11 алба хаагч болон тус хэлтсээр үйлчлүүлж байсан 8 иргэн нэгдсэн дадлага сургуулилтанд хамрагдсан. Мөн Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/11 дугаартай захирамж, Чингэлтэй дүүргийн Онцгой комиссын даргын 07 тоот захирамжийн дагуу дүүргийн хэмжээнд 2017 оны 05 дугаар сарын 11, 12-ны өдрүүдэд зохион явуулсан гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулилтад Чингэлтэй дүүрэг дэх Замын цагдаагийн хэлтсийн бие бүрэлдэхүүн хамрагдаж зохион байгуулалттай арга хэмжээнд идэвхтэй оролцож, Гамшгийн үеийн удирдлагын байрны үйл ажиллагааг 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр Нийслэлийн онцгой байлын газар болон Нийслэлийн цагдаагийн газрын холбогдох мэргэжилтэн, алба хаагч нар гамшгийн үеийн нөхцөл байдлыг үнэлж зохион байгуулсан ажлыг шалгасны үр дүнд 93,7% буюу маш сайн үнэлгээ авсан.

Алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хэлтсийн дарга, ахлах зохицуулагч нар алба хаагчдын, ар гэрээр орж, ахуй амьдралтай танилцаж судалгаа гаргах хуваарийг гаргаж 2017 оны 01 сарын 04-нөөс 2017 оны 01 сарын 10-ны өдрүүдэд хэлтсийн дарга, ахлах зохицуулагч нар хэрэг бүртгэгч, зохицуулагч, цагдаа зохицуулагч нарын ар гэр ахуй амьдралтай нь танилцаж, тэднээс гаргаж байгаа санал хүсэлтийг сонсож 12 төрлийн судалгаа авсан. Нийт алба хаагчдын 27 буюу 50,9% нь орон сууцанд, 20 буюу 37,7% нь хашаа байшинд, 6 буюу 11,3% нь түрээсийн орон сууц, хашаа байшинд тус тус амьдарч байна. Үүнээс 48 буюу 81,2% нь орон сууц, хашаа байшин, автомашин болон цалингийн зээлтэй байна. Амьдралын баталгаажих түвшингээс доогуур орлготой 7 албан хаагч байгаа нь нийт алба хаагчдын 13,2 хувийг, иргэний бүртгэлийн хаягтай оршин суух хаягийн зөрүүтэй 16, гэрлээгүй 12, автомашинтай 22 алба хаагч тус тус байна. Алба хаагчдаас дотооддоо удаа дараа зөрчил заагдсан, гадны нөлөөнд автах магадлалтай алба хаагчдын судалгааг гаргаж, 2017 оны 05 сарын 31-ний өдөр ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч Ц.Чинзориг ЗЦА-ны Сэтгэл зүйч, цагдаагийн ахмад Э.Бямбажаргалын хамт 3 зохицуулагчийн гэрээр, ахлах зохицуулагч, цагдаагийн ахмад Б.Зоригт 3 цагдаагийн ар гэрээр орж гэр бүлийн гишүүдтэй уулзаж ярилцсан. Мөн анхаарал татсан сахилга ёс зүйтэй холбоотой зөрчил гаргаж болзошгүй нэр бүхий 5 цагдаа зохицуулагчийн ар гэрээр зохицуулагч нарыг оруулж тэдний гэр бүлийнхэнтэй уулзаж, ахуй амьдралын талаар судалгаа авч, тэднээс гаргасан саналыг нэгтгэн 2017 оны 08 дугаар сарын 16-ны өдөр Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын газрын даргад танилцуулсан. Алба хаагчдыг сэтгэл зүйн хямралаас үүдэлтэй сэтгэл гутрал, уур бухимдлаас салгах үүднээс 2017 оны 01 сард нэг бүрчлэн, дотооддоо удаа дараа зөрчил заагдсан, гадны нөлөөнд автах магадлалтай нэр бүхий 6 алба хаагчийн ар гэрээр 2017 оны 05 дугаар сард, иргэдтэй зүй бус харьцсан, харилцааны доголдол гаргасан 3 алба хаагчтай 2017 оны 11 сард тус тус Замын цагдаагийн албаны сэтгэл зүйч цагдаагийн ахмад Э.Бямбажаргалыг урьж нийт 3 удаа алба хаагчидтай нэг бүрчлэн ганцаарчлан болон тэдний гэр бүлийн гишүүдтэй уулзуулж сэтгэл зүйн зөвлөгөө өгүүлэх зэрэг ажлыг зохион байгуулсан. Мөн алба хаагчдын гэр бүлийн гишүүдтэй 2017 оны 01 сарын 28, 09 сарын 08-ны өдрүүдэд хэлтсийн хурлын зааланд 2 удаа уулзалт зохион байгуулж, хэлтсээс алба хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн асуудлыг сайжруулах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажил, цаашид хийхээр төлөвлөж байгаа ажлын талаар товч танилцуулж, албаны үйл ажиллагаатай холбоотой санал хүсэлтийг сонсож харилцан ярилцсан. Хэлтсийн алба хаагчдын гэр бүлийн гишүүдийн төлөөлөл болгож “Гэр бүлийн гишүүдийн зөвлөл”-ийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Алба хаагчийг албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх үүднээс ахлах зохицуулагч, цагдаагийн ахмад Б.Зоригт алба хаагчдад хандан зөрчил гаргасан иргэд, жолооч нартай харилцахдаа энгэрийн камераар бичлэг хийж, ажлаас буухдаа бичлэгээ хуулбарлуулж байх талаар тогтмол үүрэг өгч, алба хаагчдыг үүрэг гүйцэтгэхээс 30 минутын өмнө энгэрийн камерийн үйл ажиллагааг шалгаж, камерийн бичлэг, зургийг тухайн өдрөөр бүртгэлжүүлэн, сан үүсгэж Мэдээлэл технологийн оператор цагдаад хуулбарлуулан хадгалуулж, бүртгэлийн дэвтэр хөтөлж хэвшээд байна.

Албаны компьютер бүрийг лацдаж, нууц кодтой болгож сүлжээний болон цахилгааны утсыг далдалж, сүлжээний топологи схемийн зураглалыг Чингэлтэй дүүргийн цагдаагийн 1-р хэлтсийн мэдээлэл холбооны инженер цагдаагийн ахмад н.Оюунбаатартай хамтарч шинээр гаргаж мэдээлийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Мэдээлэл технологийн оператор цагдаа, цагдаагийн ахлагч П.Билгүүн хэрэг бүртгэгч, зохицуулагч нарын компьютерийг коджуулан тухайн кодыг улирал бүр сольж хэвшсэн.

Чингэлтэй дүүргийн Засаг дарга, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс 2017 онд алба хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, иргэдийн ая тухтай үйлчлүүлэх бололцоог хангах үүднээс хэлтсийн байрны үүдэнд өргөтгөл барих ажилд 10 сая төгрөгний хөрөнгийг шийдвэрлүүлж 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдөр өргөтгөлийг барьж ашиглалтад оруулсан.

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр алба хаагчдын өрөө, тасалгааны цахилгаан болон сүлжээний утаснуудыг далдалсан.

Мөн хэлтсийн байрны угтах үйлчилгээнд 08:00 цагаас 15:00 цагийн хооронд Олон нийтийн цагдааг, 15:00 цагаас 08:00 цаг хүртэл хэлтсийн алба хаагчдыг ажиллуулж байна. Хэлтсийн байранд жижүүрээр ажиллаж байгаа алба хаагчид, алба хаагчдын цагийн бүртгэл, гадуур явсан бүртгэл, лацны бүртгэл, эд аж ахуй хүлээлцсэн бүртгэлийг тус тус хөтөлж хэвшсэн бөгөөд хоногийн хугацаанд хэрхэн ажилласан талаарх рапортыг бичиж өглөө бүр ахлах зохицуулагч нар биечлэн танилцаж хяналт тавин ажиллаж байна.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 10 дугаар сарын 02-ны хэлтсийн байрны халаалт тавих ажлыг эхлүүлж, замын цагдаагийн албаны слесарь ирж ажилласан бөгөөд бүсийн 104 тоот өрөө, хэлтсийн үүдний хүлээлгийн танхимд паарны боолт муудаж ус алдаж байсныг солиулсан.

Мөн хэрэг бүртгэгч нар байцаалт, мэдүүлгийн өрөөтэй болгох ажлын хүрээнд өрөөний хэмжээ 8м² хэтрэхгүй байх, агааржуулагчтай байх, дулаан хэмжигчтэй байх зэрэг шаардлагуудыг хангаж, хэрэг бүртгэлтийн өрөө, болон бүсийн өрөөг стандартын дагуу тохижуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Тав. Дотоод хяналтын хүрээнд:

а. Байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийсэн байдал:

Тус хэлтсээс Цагдаагийн ерөнхий газрын даргын 01 тоот албан даалгаврын хүрээнд хэлтсээс хийж хэрэгжүүлсэн ажлын биелэлтийг хагас бүтэн жилээр гаргаж биелэлт үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж Захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын нэрэмжит 2016 оны иж бүрэн шалгалтын хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын дэд даргын 2016 оны 10 сарын 12-ны өдрийн 3/1489 тоот үүрэг ажлын чиглэлийн дагуу хэлтсээс зохион байгуулах ажлын төлөвлөгөөний биелэлийг 11 сарын 15-ны байдлаар гаргаж ЦБҮАЖ /код-110/-ийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг тооцсон.

Замын цагдаагийн албаны даргын 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр баталсан “Харьяа дүүрэг дэх Замын цагдаагийн хэлтэст төлөвлөгөөт бус шалгалт явуулах

удирдамж"-ын дагуу Чингэлтэй дүүрэг дэх Замын цагдаагийн хэлтсийн ажлыг 2017 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Захиргаа удирдлагын хэлтсийн чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа Ж.Шаравнямбуу, ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад Б.Наранцогт нар "Цагдаагийн байгууллагын дотоод албаны дүрэм"-ийг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар шалгаж үнэлэлт дүгнэлт өгсөн.

б. Хяналт шалгалт, албаны шалгалтын талаар:

Алба хаагчдын сахилга, ёс зүй, албаны бэлэн байдлыг сайжруулах чиглэлээр энэ оны эхний 10 сард сахилгын хурлыг нийт 35 удаа, сахилгын зөвлөгөөнийг 3 удаа тус тус зохион байгуулаад байна. Хурлаар дээд шатны байгууллага, алба тушаалтаас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэл, зөвлөмжийг биелэлтийг хангуулах, хэлтсийн албаны үйл ажиллагааг сайжруулах, алба хаагчдаар тодорхой төрлийн ажил, үүрэг гүйцэтгүүлэх, алба хаагчдын өдөр тутмын ажлын үр дүнг сайжруулах ажлын хүрээнд хэлтсийн дарга, ахлах зохицуулагч нараас 2017 оны эхний 10 сарын байдлаар 122 удаагийн үүрэг, ажлын чиглэл, 54 удаагийн зөвлөмж, зааварчилгааг бичгээр болон хэлтсийн хурлын тэмдэглэлээр өгч үр дүнг тухай бүрд нь тооцож ажилласан байна. Хэлтсийн алба хаагчдаас 2017 оны эхний 10 сарын байдлаар ЁС журам болон ЗЦА-ны ерөнхий эргүүл /А-9/-ийн рапортод техник замын зохион байгуулалт, хэлтэс болон алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой 21 зөрчил заагдсан. Дээрх зөрчлийг ангилан үзвэл ажилдаа хариуцлаггүй хандсан-6 буюу 28,5%, биет зохицуулалтыг зохих журмын дагуу гүйцэтгээгүй-1 буюу 4,7%, цэрэгжилт жагсаалч байдал хангалтгүй-1 буюу 4,7%, дүрэмт хувцасны зөрчилтэй-3 буюу 14,2%, архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн-1 буюу 14,2%, хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой 4 буюу 19 хувийг тус тус эзэлж байна. Дээрх зөрчилд холбогдсон алба хаагчдыг албан тушаалаар нь авч үзвэл офицер-10 буюу 47,6%, цагдаа-4 буюу 19 хувийг эзэлж байна.

Алба хаагчдын, ар гэрээр орж, ахуй амьдралтай танилцаж судалгаа гаргах хуваарийг гаргаж 2017 оны 01 сарын 04-нөөс 2017 оны 01 сарын 10-ны өдрүүдэд хэлтсийн дарга, ахлах зохицуулагч нар хэрэг бүртгэгч, зохицуулагч, цагдаа зохицуулагч нарын ар гэр ахуй амьдралтай нь танилцаж, тэднээс гаргаж байгаа санал хүсэлтийг сонсож 12 төрлийн судалгаа авсан. Нийт алба хаагчдын 27 буюу 50,9% нь орон сууцанд, 20 буюу 37,7% нь хашаа байшинд, 6 буюу 11,3% нь түрээсийн орон сууц, хашаа байшинд тус тус амьдарч байна. Үүнээс 48 буюу 81,2% нь орон сууц, хашаа байшин, автомашин болон цалингийн зээлтэй байна. Амьдралын баталгаажих түвшингээс доогуур орлоготой 7 албан хаагч байгаа нь нийт алба хаагчдын 13,2 хувийг, иргэний бүртгэлийн хаягтай оршин суух хаягийн зөрүүтэй 16, гэрлээгүй 12, автомашинтай 22 алба хаагч тус тус байна. Алба хаагчдаас дотооддоо удаа дараа зөрчил заагдсан, гадны нөлөөнд автах магадлалтай алба хаагчдын судалгааг гаргаж, 2017 оны 05 сарын 31-ний өдөр ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч Ц.Чинзориг ЗЦА-ны Сэтгэл зүйч, цагдаагийн ахмад Э.Бямбажаргалын хамт 3 зохицуулагчийн гэрээр, ахлах зохицуулагч, цагдаагийн ахмад Б.Зоригт 3 цагдаагийн ар гэрээр орж гэр бүлийн гишүүдтэй уулзаж ярилцсан. Мөн анхаарал татсан сахилга ёс зүйтэй холбоотой зөрчил гаргаж болзошгүй нэр бүхий 5 цагдаа зохицуулагчийн ар гэрээр зохицуулагч нарыг оруулж тэдний гэр бүлийнхэнтэй уулзаж, ахуй амьдралын талаар судалгаа авч, тэднээс гаргасан саналыг нэгтгэн 2017 оны 08 дугаар сарын 16-ны өдөр Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын газрын даргад танилцуулсан. Алба хаагчдыг сэтгэл зүйн хямралаас үүдэлтэй сэтгэл гутрал, уур бухимдлаас салгах үүднээс 2017 оны 01 сард нэг бүрчлэн, дотооддоо удаа дараа зөрчил заагдсан, гадны нөлөөнд автах магадлалтай нэр бүхий 6 алба хаагчийн ар гэрээр 2017 оны 05 дугаар сард, иргэдтэй зүй бус харьцсан, харилцааны доголдол гаргасан 3 алба хаагчтай 2017 оны 11 сард тус тус Замын цагдаагийн албаны сэтгэл зүйч цагдаагийн ахмад Э.Бямбажаргалыг урьж нийт 3 удаа алба хаагчидтай нэг бүрчлэн ганцаарчлан болон тэдний гэр бүлийн гишүүдтэй

уулзуулж сэтгэл зүйн зөвлөгөө өгүүлэх зэрэг ажлыг зохион байгуулсан. Мөн алба хаагчдын гэр бүлийн гишүүдтэй 2017 оны 01 сарын 28, 09 сарын 08-ны өдрүүдэд хэлтсийн хурлын зааланд 2 удаа уулзалт зохион байгуулж, хэлтсээс алба хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн асуудлыг сайжруулах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажил, цаашид хийхээр төлөвлөж байгаа ажлын талаар товч танилцуулж, албаны үйл ажиллагаатай холбоотой санал хүсэлтийг сонсож харилцан ярилцсан. Хэлтсийн алба хаагчдын гэр бүлийн гишүүдийн төлөөлөл болгож “Гэр бүлийн гишүүдийн зөвлөл”-ийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Алба хаагчдын албан үүргээ хэвийн гүйцэтгэхэд нөлөөлөх сэтгэл зүйн тусламж, үйлчилгээг үзүүлэх, зорилгоор Замын цагдаагийн албаны Сэтгэл зүйч, цагдаагийн ахмад Э.Бямбажаргалыг урьж алба хаагчдын сэтгэл санааны байдлыг тодруулж, иргэдтэй харилцах харилцаанд үнэлэлт өгч албаны болон алба хаагчдын дунд эерэг харилцаа хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр 2017 оны 01 дүгээр сарын 11,12-ны өдөр хооронд ажиллуулсан. Үүнд:

Алба хаагчдын хүн тус бүрийн онцлогоос хамаарч оюун ухааны янз бүрийн арга барил ба үйлдэмжийн төлөвшил, хөгжлийн түвшин, сэтгэл хөдлөл, зоригийн онцлог, харилцааны шинж, бие хүмүүсийн хоорондын харилцааны онцлогийг илрүүлэхэд чиглэгдсэн судалгааг алба хаагчдаас авч судалсан судалгааны үр дүнг 21 алба хаагчдад танилцуулан зөвлөгөө өгсөн. 36 алба хаагчтай 5 удаа, 4 цагийн фокус ярилцлага хийсэн бөгөөд 12 алба хаагчтай ганцаарчилсан ярилцлага хийн ажлын байрны болон сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг олж илрүүлэн, тэдэнд сэтгэл зүйн тусламж дэмжлэг үзүүлэн ажилласан. Хэлтсийн 18 алба хаагчаас харилцах чадварын сорилоор судалгаа авч 36 алба хаагчид харилцааны чиглээр зөвлөмж бэлтгэн өгсөн. 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдөр сэтгэл зүйч, цагдаагийн ахмад Э.Бямбажаргалыг урьж хэлтсийн байранд ажиллуулж, алба хаагчдын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалахад, эрсдэлт байдлаас урьдчилан сэргийлэх сэтгэл санааны байдлын тандалт судалгааг 27 алба хаагчаас авсан.

Хэлтсийн алба хаагчдаас 2017 оны эхний 10 сарын байдлаар дотооддоо Сахилга, ёс зүйн **37** зөрчилд нийт **19** алба хаагч зөрчил заагдсаны **23** буюу **62,1** хувь нь офицер, **14** буюу **37,8** хувь нь ахлагч бүрэлдэхүүн эзэлж байна. Ахлах зохицуулагч нар дотооддоо илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулж долоо хоногийн Даваа гаригт сахилгын хурлаар оруулж зөрчил заагдсан алба хаагчдын гаргасан зөрчлийн талаар хэлэлцэн, ажлын үр дүнг тооцон дахин зөрчил дутагдалгүй ажиллах талаар үүрэг, зааварчилгаа өгч биелэлтэн дээр нь хяналт тавин ажиллаж байна. Хурлаар дээд шатны байгууллага, алба тушаалтаас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэл, зөвлөмжийг биелэлтийг хангуулах, хэлтсийн албаны үйл ажиллагааг сайжруулах, алба хаагчдаар тодорхой төрлийн ажил, үүрэг гүйцэтгүүлэх, алба хаагчдын өдөр тутмын ажлын үр дүнг сайжруулах ажлын хүрээнд хэлтсийн дарга, ахлах зохицуулагч нараас 2017 оны эхний 10 сарын байдлаар 122 удаагийн үүрэг, ажлын чиглэл, 54 удаагийн зөвлөмж, зааварчилгааг бичгээр болон хэлтсийн хурлын тэмдэглэлээр өгч үр дүнг тухай бүрд нь тооцож ажилласан байна.

Зургаа. Дүгнэлт:

Дүүргийн нутаг дэвсгэрт 2016, 2017 онд зам тээврийн ослын улмаас хүний амь нас хохирсон, гэмтсэн ослын шалтгаан нөхцөлийн судалгааг улирал бүр гаргаж, судалгаанд үндэслэн дээрх судалгааг үндэслэн дүүргийн нутаг дэвсгэрт хэлтсээс “Зуслан хяналт-шалгалт”, “Зогсолт зогсоол-дэг журам”, “Хурд” зэрэг хэсэгчилсэн 8 арга хэмжээг зохион явуулж цагдаагийн нийтлэг үүргээр 51, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 42, зөрчил гаргасан 1525 хүнийг 41,175,000 төгрөгөөр торгож арга хэмжээ авсан. Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, зөрчлийн илрүүлэлтийг ахиулах зорилгоор зохион байгуулсан нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний үр дүнг энэ оны эхний 10 сарыг өмнөх оны мөн үетэй харьцуулан үзэхэд:

Зөрчлийн илрүүлэлт 89304 буюу 46,1%-иар, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 2275 буюу 14,7%-иар тус тус өссөн, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 35,2%-иар, зам тээврийн ослын улмаас хүний амь нас хохирсон хэрэг 2016 онд 10, 2017 онд 10 буюу 0%-иар, гэмтсэн хүн 39,5%-иар, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 42,6%-иар тус тус буурсан үр дүн гарсан байна.

Хэлтсийн алба хаагчдаас 2017 оны эхний 11 сарын байдлаар Ёс журам болон ЗЦА-ны ерөнхий эргүүл /А-9/-ийн рапортод техник замын зохион байгуулалт, хэлтэс болон алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой 21 зөрчил заагдсан. Дээрх зөрчлийг ангилан үзвэл ажилдаа хариуцлаггүй хандсан-6 буюу 28,5%, биет зохицуулалтыг зохих журмын дагуу гүйцэтгээгүй-1 буюу 4,7%, цэрэгжилт жагсаалч байдал хангалтгүй-1 буюу 4,7%, дүрэмт хувцасны зөрчилтэй-3 буюу 14,2%, архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн-1 буюу 14,2%, хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой 4 буюу 19 хувийг тус тус эзэлж байна. Дээрх зөрчилд холбогдсон алба хаагчдыг албан тушаалаар нь авч үзвэл офицер-10 буюу 47,6%, цагдаа-4 буюу 19 хувийг эзэлж байна. Алба хаагчдын сахилга, ёс зүй, албаны бэлэн байдлыг сайжруулах чиглэлээр энэ оны эхний 11 сард сахилгын хурлыг нийт 38 удаа, сахилгын зөвлөгөөнийг 3 удаа тус тус зохион байгуулаад байна. Хурлаар дээд шатны байгууллага, алба тушаалтаас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэл, зөвлөмжийг биелэлтийг хангуулах, хэлтсийн албаны үйл ажиллагааг сайжруулах, алба хаагчдаар тодорхой төрлийн ажил, үүрэг гүйцэтгүүлэх, алба хаагчдын өдөр тутмын ажлын үр дүнг сайжруулах ажлын хүрээнд хэлтсийн дарга, ахлах зохицуулагч нараас 2017 оны эхний 10 сарын байдлаар 122 удаагийн үүрэг, ажлын чиглэл, 54 удаагийн зөвлөмж, зааварчилгааг бичгээр болон хэлтсийн хурлын тэмдэглэлээр өгч үр дүнг тухай бүрд нь тооцож ажилласан байна. Дээрх зөрчлийг өмнөх оны мөн үетэй харьцуулан үзвэл 1 буюу 4,5 хувиар буурсан үр дүнтэй байна.

Чингэлтэй дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газраас 2017 онд 50 сая төгрөгний хөрөнгийг шийдвэрлүүлж 40 сая төгрөгөөр шаардлагатай техник тоног төхөөрөмжийг авч албаны үйл ажиллагаанд ашиглаж, 9,8 сая төгрөгөөр хэлтсийн байрны гадна талд 2*4 хэмжээтэй өргөтгөлийг барьж ашиглалтад оруулснаар алба хаагчдын ажиллах нөхцөл бололцоо сайжирч, хэлтсээр үйлчлүүлж байгаа иргэдийн ая тухтай орчинг бүрдүүлсэн ажил болсон. Алба хаагчдын нийгмийн асуудлыг сайжруулах чиглэлээр судалгаанд үндэслэсэн шат дараалсан ажил, арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулснаар 32 айлын зуслангийн газартай, түрээсийн хашаа байшинд амьдарч байсан 2 алба хаагчид 2 айлын 0,7 га газар олгуулсан, “Аз жаргалын эрэл”-д реалити шоунд 1 алба хаагчийг оролцуулан дэмжиж 2 өрөө байраар шагнуулсан, 1 алба хаагчийг орон сууцны 0,8 хувийн зээлд хамруулсан, 1 алба хаагчийн байшин барих ажилд дэмжлэг үзүүлсэн зэрэг ажлуудыг зохион байгуулсан нь алба хаагчид албандаа итгэх итгэлийг нэмэгдүүлсэн бодитой ажил болсон.

ТАЙЛАН БИЧСЭН:

ЗОХИЦУУЛАГЧ,
ЦАГДААГИЙН АХМАД

Б.АЛТАНДӨШ

ХЯНАСАН:

АХЛАХ ЗОХИЦУУЛАГЧ,
ЦАГДААГИЙН АХМАД

Б.ЗОРИГТ

ТАНИЛЦСАН:

ХЭЛТСИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Д.ГАНБОЛД